

Төрийн байгууллагын Мэдээллийн цахим ил тод байдлын индекс 2024



Мониторингийн тайлан

“Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын индекс 2024: Мониторингийн тайлан”-г IRIM судалгааны хүрээлэн өөрсдийн санаачилгаар 13 дах жилдээ хийж гүйцэтгэв.

Мониторингийн тайлангийн үр дүнг ашиглах бол эх сурвалжийг дурдана уу.

IRIM. Цахим ил тод байдлын индекс, УБ., 2024

Мониторингийн баг

Хүрэлчулуун Баярмаа
Ахлах судлаач




Баянбат Шинэцэцэг
Зохицуулагч, Судлаач

Болдын Болор
Судлаач

Эх бэлтгэл, дизайн

Болдын Болор
Судлаач

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ СУДАЛГААНЫ ӨМНӨХ ТАЙЛАНГУУД



* Зураг бүр дээр дарж тайлан тус бүртэй танилцах боломжтой. Нийт тайланг: <http://irim.mn/web-monitoring>

АГУУЛГА

Удиртгал	5
1. Арга зүй	7
1.1. Индексийн зорилго, зорилт	7
1.2. Индексийн хүрээ	8
1.3. Индексийн бүтэц ба хэмжих аргачлал	11
2. Үр дүн	13
2.1. Нэгдсэн үр дүн	13
2.1.1. Цахим ил тод байдлын өөрчлөлт	13
2.2. Бүрэлдэхүүн тус бүрийн үр дүн	14
2.2.1. Цахим ил тод байдлын индексийн Олон улс дахь төлөв байдал	15
2.2.2. Мэдээллийг ил тод болгох бодлогын орчны нөхцөл байдал	17
2.2.3. Төрийн байгууллагын мэдээллийг ил тод болгох чадамж, бэлэн байдал	19
2.2.4. Цахим мэдээллийн нээлттэй байдал	21
2.3. Байгууллагуудын үр дүн	24
3. Дүгнэлт, зөвлөмж	25
Хавсралт 1. Арга зүй: Хэмжих индикаторууд, харгалзах оноо	27
Хавсралт 2. Байгууллагын төрөл тус бүрийн эрэмбэ	28
Хавсралт 3. Нийт үнэлсэн төрийн байгууллагуудын эрэмбэ	32

Удиртгал

Мэдээлэл харилцаа, холбооны технологи (МХХТ) нь орон зай, газар зүйн байршлаас үл хамааран мэдээллийг нээлттэй, ил тод, хурдан шуурхай хүргэх боломжийг бий болгодог. Гэвч дэлхий даяар энэхүү технологийн дэвшилд нийцэж, дасан зохицох, хөгжих явцад сорилтууд тулгарч буй бөгөөд энэ нь ялангуяа төрийн байгууллагад илүү мэдрэгдэж байна. Төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангах, мэдээлэл авах эрхийг сайжруулахын тулд МХХТ-ийн боломжийг үр дүнтэй ашиглах шаардлагатай. Үүний зэрэгцээ иргэдийн зүгээс төрийн мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх хүсэлт, шаардлага өсөн нэмэгдсээр байгаа. Энэхүү шаардлага болон хэрэгцээ хэр түвшинд хангагдаж чадаж байгаа талаар хэмжих, үр дүнд тулгуурлан сайжруулах оролдлогууд хийгдсээр байна.

Үүний нэг томоохон хэмжүүр нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ)-ийн Цахим засаглалын хөгжлийн индекс (E-Government Development Index, EGI) бөгөөд 2002 оноос хойш улс орнуудыг тогтмол үнэлж байна. Энэ индекс нь цахим засаглалын хөгжлийн ерөнхий байдлыг дүгнэх чухал үзүүлэлт юм.

2024 оны "Цахим засаглалын хөгжлийн индекс"-ийн тайланд дараах орнууд тэргүүлжээ:

1. Дани – 0.9847 оноо
2. Эстони – 0.9758 оноо
3. Сингапур – 0.9691 оноо
4. Өмнөд Солонгос – 0.9679 оноо
5. Ирланд – 0.9643 оноо

Эдгээр орнууд нь цахим засаглалын хөгжлөөрөө дэлхийд тэргүүлж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр иргэддээ хүртээмжтэй, үр ашигтай хүргэж буйг харуулж байна. Монгол Улс энэ удаагийн үнэлгээгээр

0.8457 оноо авч, 193 орноос 46-р байрт жагссан нь өмнөх 2022 оны 74-р байраас 28 байраар ахисан үзүүлэлт юм. Мөн цахим оролцооны индексээр 0.7808 оноотойгоор 193 орноос 37-р байрт орсон нь 2022 оны 57-р байраас 20 байраар ахисан үзүүлэлттэй байна. Эдгээр ахиц нь Монгол Улс 2022 оноос цахим хөгжил хариуцсан яамтай болсноор өдгөө цахим засаглалын хөгжилд томоохон дэвшил гарахад чухал нөлөөтэй байсныг харуулж байна.

Монгол Улсад цахим засаглалыг хөгжүүлэх үндэс суурь нь 2004 онд батлагдсан "Цахим Монгол" үндэсний хөтөлбөр юм. Энэ хөтөлбөр нь иргэдэд хандсан, үр дүнтэй, хэмнэлттэй төрийн үйлчилгээг хөгжүүлэх зорилготойгоор байгууллага бүр цахим хуудастай байх, иргэн бүр цахим шуудангийн хаягтай болох, төрийн үйлчилгээг онлайнаар хүргэх зорилтууд дэвшүүлэн ажиллаж эхэлсэн юм. Хурдацтай хөгжиж буй мэдээлэл технологийн энэхүү цахимжуулах үйл явц 20 жилийн дараа гэхэд хиймэл оюун ухаан (ХОУ)-ыг хэрхэн ашиглах тухай шинэ шатанд тулж ирээд байна. Хиймэл оюун ухааны асар хурдацтай хөгжил явагдаж, дэлхий нийтэд 2024 онд хамгийн чухал сэдвийн нэг болсон. Хиймэл оюун ухааныг боловсрол, эрүүл мэндийн салбарт аль хэдийн өргөн хэрэглэж эхлээд байгаа бөгөөд улс орнууд ч энэ чиглэлээр ямар бодлого, стратеги баримтлахаа тодорхойлж баталж эхэллээ. Манай улсын хувьд ч Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран Монгол Улсын хиймэл оюун ухааны үндэсний стратегиа боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээд байна. Энэ хүрээнд 2025 оны 2-р сарын 13-нд "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги"-аа танилцуулж, олон нийтийн хэлэлцүүлэгт орууллаа. . Стратегийн гол

зорилго нь уул уурхай, эрчим хүчний салбарт хиймэл оюуныг түлхүү нэвтрүүлэхэд чиглэж байна. Монгол Улсын эрс тэс уур амьсгал, сэргээгдэх эрчим хүчний нөөц нь эрчим хүчний хэмнэлттэй дата төвүүдийг байгуулах таатай орчин бүрдүүлэх тул эдгээр салбарт хиймэл оюуныг ашиглах нь эдийн засгийн өсөлтөд чухал хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

Харин хиймэл оюун ухааныг олон нийт өгөгдөл, мэдээлэл боловсруулах, мэдээлэл эрж хайх, хүлээн авах чиглэлээр түгээмэл ашиглах болжээ. Тиймээс хиймэл оюун ухаанаас хүлээн авч буй мэдээллийн үнэн зөв, найдвартай байдал өдгөө чухалд тооцогдож байна. Төрийн байгууллага өөрийн цахим хуудас болон бусад албан ёсны сувгаараа мэдээллийг олон нийтэд түгээх нь иргэд үнэн зөв, найдвартай мэдээллийг баталгаажуулах нэг эх сурвалж болдог тул хиймэл оюун ухааны тусламжтайгаар хэрхэн өөрсдөд байгаа өгөгдөл, мэдээллийг ашиглан мэдээллийн урсгалд оруулах чиглэлээр цаашид анхаарах шаардлагатай юм.

Oxford Insight байгууллагын гаргасан “ХОУ-ын бэлэн байдлын индекс”-ээр Монгол Улс 2024 онд 11 байр урагшилж, 188 орноос 98-д эрэмбэлэгдсэн байна. Энэ нь ХОУ-ын хөгжүүлэлт, дэд бүтэц, өгөгдлийн нээлттэй байдал зэрэгт ахиц гарсныг илтгэнэ.

Үүнтэй зэрэгцэн төрийн байгууллагуудын мэдээллийг нээлттэй болгох үйл явц эрчимжиж, мэдээллийг нэгтгэн иргэд, олон нийт, хэвлэл мэдээллийнхэнд нэг дороос мэдээлэлд хяналт тавих боломжийг олгож байгаа нь иргэдийн үндсэн хуулиар олгогдсон мэдээлэл авах эрхийг дэмжсэн нэн чухал ач холбогдолтой ажил болж байна.

Монгол Улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт мэдээллийн технологид тулгуурлан төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, хөдөө орон нутагт мэдээлэл, харилцаа холбооны шинэлэг үйлчилгээ нэвтрүүлэх, өндөр

хурдны сүлжээнд холбох, цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтцийг өргөтгөн хөгжүүлэх зорилтуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд энэ зорилтыг хэрэгжүүлэхэд 2023 онд Монгол Улсын Засгийн газраас зарласан “Авлигатай тэмцэх жил”-ийн хүрээнд “5Ш” ажиллагааны нэг хэсэг болох “Шилэн ажиллагаа” нь чухал үүрэг гүйцэтгэж байна. Шилэн ажиллагаа нь Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын удирдлага дор төрийн бүх түвшний байгууллагуудын мэдээллийг Shilen.gov.mn цахим платформ дээр нийтэлж, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан 68 төрлийн мэдээллийг 98 шалгуур үзүүлэлтээр дүгнэн үнэлж, мэдээллээ улирал бүрд оруулах болсон. Энэ хүрээнд 2023, 2024 оны төрийн бүх шатны байгууллагын нээлттэй мэдээлэл, нотлох баримтууд, онооны хамт олон нийтэд нээлттэй байдлаар байршиж байна.

Энэхүү ажиллагаа нь нийтлэгдсэн мэдээллүүд иргэд болон олон нийтийн хяналтад өртөх боломжийг бүрдүүлснээр төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын хариуцлагыг нэмэгдүүлж, иргэдийн төрд итгэх итгэлийг тодорхой хэмжээнд сайжруулахад хувь нэмэр оруулсан юм. Мөн энэхүү платформоор дамжуулж иргэдийн төрийн байгууллагуудын талаар санал, гомдол, хүсэлтээ өгөх боломжийг хялбаршуулсан нь төр, иргэдийн харилцааг илүү нээлттэй, үр дүнтэй болгоход чиглэсэн чухал алхам болсон. Гэвч цаашид платформын тогтвортой байдлыг хангах үүднээс байгууллагууд мэдээллээ тогтмол, тасралтгүй шинэчилж оруулах үүргээ биелүүлэх, серверийн аюулгүй байдал болон өгөгдлийн чанарыг сайжруулах, мэдээлэл боловсруулах чадамжийг нэмэгдүүлэх, мэдээлэл оруулах ажилтнуудын чадавхыг сайжруулах зэрэгт онцгой анхаарах шаардлага гарч байна.

Энэхүү тайлан нь төрөөс нийтэд цахим технологиор дамжуулан хүргэж буй мэдээллийн цар хүрээ, чадавхыг үнэлэх зорилгоор 13 дахь жилдээ боловсруулан хүргэж байна.

1. Арга зүй

1.1. Индексийн зорилго, зорилт

Индекс нь төрийн байгууллагуудын мэдээллийн цахим ил тод байдлыг тоон үзүүлэлтээр хэмжиж, нийт үр дүнг улсын хэмжээнд тооцоолсноор цаашид Засгийн газар болон төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой. Энэ зорилгын хүрээнд дэвшүүлсэн мониторингийн гол зорилтууд нь:

- Төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын түвшнийг хэмжиж, эрэмбэлэх
- Үр дүнг өмнөх жилүүдтэй харьцуулах
- Цаашид сайжруулахад чиглэсэн санал, зөвлөмж боловсруулах

Индексийн үр дүнд тулгуурлан байгууллага бүр өөрийн давуу болон сул талыг танин мэдэх боломжийг олгохын тулд харьцуулсан дүн шинжилгээг хийж гүйцэтгэсэн. Цаашид уг индексийг байгууллагууд бие биеэсээ суралцах, цахим мэдээлэл түгээх чадавх болон сорилт, бэрхшээлийг тодорхойлох, энэ чиглэлийн бодлого, стратегийг тодорхойлох хэрэгсэл болгон ашиглахыг санал болгож байна.

Индексийн үр дүнг тооцон гаргахдаа дараах төрийн байгууллагуудыг жил бүр хамруулдаг (Зураг 1).

2024 оны УИХ-ын сонгуулийн үр дүнгээр Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдөн зохион байгуулагдсанаар энэ удаагийн үнэлгээнд 98 байгууллага хамрагдсан. 2021 онд эдгээр 6 төрлийн байгууллагын нийт тоо 88, 2022 онд 93 байсан бол 2023 онд 98 байв.

ЗУРАГ 1

Төрийн мэдээллийн цахим ил тод байдлыг тооцон гаргахад хамруулсан байгууллагууд



1.2. Индексийн хүрээ

Хэдийгээр сүүлийн жилүүдэд техник, технологи, хиймэл оюун ухаан зэрэг хүний оролцоо, хөдөлмөр хөнгөвчлөх хөгжил дэвшлийн шийдлүүд нэмэгдэж, цомхон бүтэц бүхий үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн аль ч салбарт эрхэмлэж байгаа ч энэхүү чиг хандлагын эсрэг улам данхгар бүтэцтэй болж, энэ хэрээр төрийн татаас нэмэгдэж байгаа талаар олон нийт шүүмжлэх болсон.

Иргэд төрөөс үнэн, зөв мэдээллийг хүлээн авах, хайх эрхийг олон улсын гэрээ, конвенц болон үндэсний эрх зүйн баримт бичгүүддээ тусган баталгаажуулсан байдаг. Монгол Улсын 1974 онд соёрхон баталсан НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын фактын 19.2-т “Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэ эрхэд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана”, 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйл Монгол Улсын иргэний эдлэх үндсэн эрх, эрх чөлөөний 17-д төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй гэж заасан нь ардчилсан тогтолцоот улс болохын хувьд төрийн ил тод байдлыг хангах, иргэд төрийн мэдээллийг хүлээн авах эрх зүйн үндэс суурь болсон.

Төр өөрийн санаачилгаар олон нийтэд мэдээллийг аль болох хүртээмжтэй, идэвхтэй түгээх нь хамгийн хэмжих боломжтой, чиг үүргийнх нь дагуу сайжруулах боломжтой суваг юм. Мэдээллийг түгээхдээ цахим хэрэгсэл ашиглах нь мэдээллийн дотоод эх сурвалж буюу мэдээлэгчийн мэдээлэл алдагдлыг хянах боломжтой болдог. Мэдээллийн ил тод байдал, цахим ил тод байдлын талаар олон улсын байгууллагуудын өөр өөрсдийн өнцгөөс тайлбарласан олон тодорхойлолтууд байдаг ч энэхүү мониторинг тайлангийн өмнөх жилүүдэд тодорхой дурдсан байдаг тул мэдээллийн ил тод байдалтай холбоотой тодорхойлолт, хэмжих арга зүйн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг <https://www.irim.mn/p/17> холбоосоор орж танилцах боломжтой юм.

Төрөөс мэдээллийг ил тод болгох үйл явц нь зөвхөн төрийн үйл ажиллагааны үр дүн бус мэдээллийг ил тод болгох орчин бий эсэх, түүнийг хэрэгжүүлэх төрийн байгууллагын чадамж байгаа эсэх, үүний үр дүнд иргэд, олон нийтэд мэдээлэл бүрэн, хялбар, хүртээмжтэйгээр хүрч буй эсэх үйл явцыг үнэлэх юм. Тиймээс мэдээллийн цахим ил тод байдлыг хэмжих загвар нь мэдээлэл авах эрхийг хангаж буй i) эрх зүйн орчин хэр бүрдсэн эсэх, ii) мэдээлэл өгөх үүрэг бүхий төрийн байгууллагын чадавх, iii) технологийн тусламжтай хүрч буй мэдээллийн агуулга нь иргэдэд бүрэн, цаг хугацаандаа хүрч чадаж байгаа эсэх зэрэг бүрэн цогцоор нь үнэлэх оролдлого юм.

ЗУРАГ 2

Цахим ил тод байдлын индексийн хүрээ



Бодлогын орчин бүрэлдэхүүн хэсэг нь тухайн улс орны мэдээллийн ил тод байдлын эрх зүй, бодлогын орчныг үнэлнэ. Бодлогын орчны бүрэлдэхүүн хэсэг, түүнд харгалзах индикаторууд нь олон улсын, тухайн улсын, байгууллагын гэсэн гурван түвшинд үнэлэгдэхийн сацуу зарим салбарын шинжтэй үзүүлэлтүүдийг хамарна. Олон улсын түвшин дэх үзүүлэлтийг тодорхойлсон индикаторын дагуу олон улсын харгалзах индексүүдийн оноог хөрвүүлэх байдлаар авч ашиглана. Түүнчлэн, тухайн улс оронд төрийн байгууллагыг мэдээллээ ил тод, нээлттэй болгох нөхцөлийг хэрхэн хангаж байгаа талаар дэлгэрэнгүй авч үзнэ. Байгууллагын түвшинд эдгээр бодлого, журмыг хэрэгжүүлэхийн тулд өөрийн байгууллагадаа тохирсон дүрэм, журмыг баталж, мөрдүүлж байгаа эсэх, хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаа эсэхэд анхаарах юм.

Байгууллагын чадамжийн бүрэлдэхүүн хэсэг нь тухайн төрийн байгууллагын мэдээллийн цахим ил тод байдлыг хангах чадавхад чиглэгдэнэ. Өмнөх жилүүдэд манай байгууллагаас хийж ирсэн 'Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын мониторинг' нь мэдээллийн ил тод байдлыг хангах явдал нь тухайн байгууллагын чадавх, нөөцөөс ихээхэн хамаардаг болохыг харуулсан.

ЗУРАГ 3

Бодлогын орчныг үнэлэх түвшин



Төрийн байгууллагын мэдээллийн цахим ил тод байдлыг хангах чадамж нь дотоод дүрэм журмын тодорхой байдлаас гадна мэдээллийг ил тод болгох тодорхой үйл явц болон хүний нөөцийн чадавх, технологи ашиглах чадамж, технологи нь мэдээллийг ил тод болгоход хэр нийцтэй ажиллаж байгаа вэ гэдгээр тодорхойлогдоно.

Цахим нээлттэй мэдээлэл бүрэлдэхүүн хэсэг олон нийтийн мэдээлэл авах эрх хангагдаж байгаа эсэхэд (гарц) төвлөрөх ба 'Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль'-д заасан 'нээлттэй'-ээр байршуулахаар заасан мэдээллийн агуулгад төвлөрч, тус хуулийн:

- 8.8-д ил тод, нээлттэй байлгах мэдээллийг олон нийтэд хүргэхдээ цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгсэл ашиглана.
- 8.12.Мэдээллийн бусад хэрэгсэл ашиглаж байгаагаас үл хамааран мэдээлэл хариуцагч цахим хуудас, мэдээллийн самбарыг заавал ажиллуулах ба цахим хуудсаар нээлттэй мэдээлэлтэй танилцах нөхцөлийг бүрэн хангана.
- 8.13.Нээлттэй мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах тохиолдолд тус мэдээллийг өгөх эх сурвалжийг цахим хуудсанд тодорхой заасан байна зэрэг заалтуудад үндэслэн үр дүнг тооцно.

Ингэхдээ зөвхөн холбогдох хууль, журамд заасан мэдээллийг байгаа эсэхийг хэмжих бус цаг хугацааны нийцтэй байдал буюу заасан цаг хугацаандаа нийтэлсэн эсэхийг давхар хянах юм. Мөн хуульд заасан нээлттэй мэдээллийн цар хүрээг хэмжихээс гадна мэдээлэл авах эрхийг хангах, эрэлтийг бий болгоход чиглэсэн үйл явц буюу эгэх холбоо байгаа эсэх нь энэ бүрэлдэхүүн хэсгийн бас нэгэн гол үзүүлэлт юм. Тиймээс цаашид иргэд, олон нийттэй харилцах, мэдээллийг шуурхай түгээхэд онцгой ач холбогдолтой зарим индикаторуудыг энэ бүрэлдэхүүнд авч үзсэн.

1.3. Индексийн бүтэц ба хэмжих аргачлал

Цахим ил тод байдлын индекс (ЦИТБИ) нь ихэнх индексийн адилаар индикаторуудыг нэгтгэж, цахим мэдээллийн ил тод байдлыг илтгэх нэгдсэн нэг оноогоор хэмжигдэнэ. Индекс нь үндэсний болон байгууллагын түвшинд илэрхийлэгдэх боломжтой байна.

Индекс нь 3 гол бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 10 дэд бүрэлдэхүүн, 35 шалгуур үзүүлэлт, түүнийг тодорхойлох 150 асуулт/үзүүлэлтээс бүрдэнэ.

Цахим ил тод байдлын индексийг тооцохдоо өмнө нь эдгээр гурван бүрэлдэхүүн хэсэгт ижил жин хуваарилдаг байсан бол энэ удаа (i) бүрэлдэхүүн тус бүрийн индикаторыг хэмжих асуултын тоо болон (ii) ач холбогдлын зэргээс шалтгаалан ялгаатай жингээр тооцох арга зүйг санал болгож байгаа юм.

- Цахим ил тод байдлын индексийн нийт 150 асуултын Бодлогын орчны бүрэлдэхүүн

57, Байгууллагын чадамж бүрэлдэхүүн 29, Цахим нээлттэй мэдээлэл 64 асуулттай байна. Ингэснээр эдгээр бүрэлдэхүүн тус бүр 38% (57/150), 19.3% (29/150) болон 42.7% (64/150) гэсэн жинтэй байна.

- Харин дараагийн хүчин зүйлд, бүрэлдэхүүн тус бүрийн ач холбогдлыг тэнцүү гэж үзэж байгаа тул 33.3% (1/3) байна.

Тиймээс бодлогын орчин нь 35.65%-аар тооцогдож байна. Хэрвээ индикатор доторх асуултын тоо өөрчлөгдвөл эхний хүчин зүйлийн жинг дээрх аргаар хувааж тооцоолно.

$$DTI = \frac{1}{l} \sum_{k=l}^k \left(\frac{1}{3} \sum_{n=25} A_n + \frac{1}{3} \sum_{n=5} B_n + \frac{1}{3} \sum_{n=5} C_n \right)$$

k-Үндсэн нэмэгч индекс
l-Байгууллагын тоо
n-Индикаторын тоо

A- Эрх зүйн орчин
B- Байгууллагын чадамж
C- Цахим нээлттэй байдал

ХҮСНЭГТ 1

Хэмжих индикаторууд болон харгалзах оноо

Код	Индикаторууд	Дээд оноо
Е. Бодлогын орчин		57
E1	Мэдээлэл авах эрх (Олон улс)	8
E2	Засаглал (Олон улс)	12
E3	Иргэний нийгэм (Олон улс)	15
E4	Улсын түвшний бодлого, зохицуулалт	14
E5	Байгууллагын түвшний зохицуулалт	8
О. Байгууллагын чадамж		29
O1	Байгууллагын ил тод байдлыг хангах үйл явц ба нөөц	12
O2	Цахим хуудасны технологийн нийцтэй байдал	11
O3	МХТ-ийн чадавх	6
Д. Цахим нээлттэй мэдээлэл		64
D1	Нээлттэй мэдээлэл	56
D2	Харилцаа холбоо ба эгэх холбоо	8
Нийт		150

ЗУРАГ 4

Индексийн үр дүнгийн утгын ангилал

Сайн	≥0.80	Цахим ил тод байдлыг бий болгох, мэдээллийг цахимаар нийтлэх процедур, нөөц, хариуцлагыг бүрэн бэхжүүлсэн.
Хангалттай	0.65-0.79	Байгууллага мэдээллийг цахимаар нийтлэх процедур, нөөц, хариуцлагыг бэхжүүлж байгаа.
Сул	0.50-0.64	Цахим ил тод байдлыг бий болгох, сайжруулахтай холбоотой зарим үзүүлэлт байгаа. Цаашид байгаа мэдээллүүдийг шинэчлэх, тогтвортой хангах чадварыг бэхжүүлэх шаардлагатай.
Хангалтгүй	0.35-0.49	Байгууллагад мэдээллийг цахимаар нийтлэх талаар суурь түвшний процедур, нөөц, хариуцлагатай, ил тод байдлыг цаашид тогтвортой хангах чадвар хомс байна.
Муу	<0.35	Байгууллагад мэдээллийг цахимаар нийтлэх процедур, нөөц, хариуцлага бараг байхгүй, энэ нь эргээд цахим хуудсаар мэдээллийг түгээхгүй байхад гол нөлөө үзүүлж байгаа.

Уг индекс нь зөвхөн тоон утгаар хэмжигдэж, ямар түвшинд байгааг тооцоолдог тул төрийн байгууллагуудын ил тод байдал яагаад буурч эсвэл нэмэгдэж байгаа талаар нарийвчилсан мэдээллийг өгөх боломж хязгаарлагдмал юм. Учир нь энэ ил тод байдлын түвшинд нөлөөлдөг хүчин зүйл болоод шинж чанаруудыг агуулдаггүй.

1.4 Үнэлгээний арга зүйн ялгаа

Сүүлийн жилүүдэд МУЗГ-аас өөрсдийн мэдээллийн ил тод байдлыг үнэлж, оноогоор харуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх болсон. Төрөөс хийж буй цахимаар нийтэлсэн мэдээллийн нээлттэй байдлын үнэлгээ нь IRIM судалгааны хүрээлэнгээс гаргадаг үнэлгээтэй төстэй бөгөөд ач холбогдлыг бууруулж байгаа мэт боловч үүнд хөндлөнгийн хараат бус үнэлгээний ач холбогдол, үнэлэх арга зүй зэрэг ялгаа заагийг тодруулж үзэх нь зүйтэй.

Тодруулбал, 2023 онд МУЗГ-аас “Авлигатай тэмцэх жил” болгон зарласан ажлын хүрээнд “5Ш” ажиллагааны нэг хэсэг болох “Шилэн ажиллагаа” нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан 68 төрлийн мэдээллийг 98 шалгуур үзүүлэлтээр үнэлж, мэдээлээ улирал бүр оруулах болсон.

Шилэн ажиллагааны үзүүлэлтүүдийг үнэлэх хүрээний хувьд тухайн төрийн байгууллагын вэб сайтад хууль ёсоор шаардлагатай нээлттэй мэдээлэл байгаа эсэхийг шалгах зорилготой бөгөөд дараах дөрвөн үзүүлэлт багтдаг:

1. Мэдээллийн хүртээмжтэй байдал
2. Хугацаандаа нийтэлсэн байдал
3. Мэдээллийн бүрэн бүтэн байдал
4. Эх сурвалжийн тодорхой байдал

Гэвч Засгийн газрын Шилэн ажиллагааг үнэлэх арга зүй нь зөвхөн тухайн вэбсайт дээрх мэдээллийг шалгахад чиглэсэн тул манай үнэлгээний арга зүйтэй (Эрх зүйн орчин, Байгууллагын чадамж, Нээлттэй мэдээлэл гэсэн гурван үзүүлэлтийн дунджаар тооцдог) шууд харьцуулах боломжгүй юм. Дээрх дөрвөн үзүүлэлт нь ЦИТБИ-ийн Нээлттэй мэдээлэл хэсгийн буюу манай байгууллагын 2021 оноос өмнө нь хэмждэг байсан Цахим хуудасны ил тод байдлын индекстэй илүү төстэй юм. Шилэн ажиллагааны үзүүлэлтүүдийг үнэлэх аргачлалын хувьд дээрх дөрвөн үзүүлэлт тус бүрийг 30 оноогоор тооцож, нийтдээ 120 онооноос

үнэлгээ гаргадаг. Тиймээс байгууллага тус бүрийн ил тод байдлын түвшнийг харвал Цахим ил тод байдлын индекстэй харьцуулахад өөр өөр үр дүнг харуулдаг бөгөөд ерөнхийдөө ихэнх байгууллагын хувьд ил тод байдал хангагдсан үр дүнтэй байна.

Гэсэн хэдий ч дөрвөн үзүүлэлт тус бүрийн хэрхэн үнэлэгдэж байгаа талаар нарийн, тодорхой шалгуур үзүүлэлт, үнэлгээний арга зүй нь нээлттэй биш байна. Энэ нь хэрэглэгчдэд ил тод байдлыг баталгаажуулах, засгийн газрын үйл ажиллагааг нээлттэй байдлаар танилцуулах чухал үүрэг гүйцэтгэдэг тул шалгуур үзүүлэлтүүдийг илүү нарийн, ойлгомжтой байдлаар платформ дээр тусдаа хэсэгт байршуулан танилцуулах хэрэгцээтэй харагдлаа. Ингэснээр олон нийт, мэргэжилтнүүд болон хэрэглэгчид үнэлгээг бүрэн ойлгож, ашиглах боломжтой болно.

Мөн, мэдээллийн бүрэн бүтэн байдлын үзүүлэлтийн хүрээнд холбооснуудын тогтмол ажиллагааг хянах, алдаа гарсан үед анхаарч засах механизмыг бий болгох хэрэгтэй. Жишээлбэл, мэдээллийн бүрэн бүтэн байдлын үнэлгээнд тухайн холбооснууд үнэлгээний үеэр хэвийн ажиллаж байсан тул бүтэн оноо авсан ч, хожим хэрэглэгчид нэвтрэхэд алдаа илэрсэн тохиолдлууд гарсан. Энэ нь үнэлгээний явцад холбоосны ажиллагааг хангалттай нарийн шалгаагүйг илтгэнэ. Тиймээс холбоосны хэвийн ажиллагааг тогтмол хянах нь платформын тасралтгүй үйл ажиллагааг баталгаажуулах, хэрэглэгчдэд үнэн зөв, найдвартай мэдээлэл хүргэхэд чухал ач холбогдолтой. Үүнийг нарийвчлан тодорхойлж, шалгуур үзүүлэлт болон үнэлгээний арга зүйг веб сайт дээрээ давхар байршуулах шаардлагатай. Ингэснээр хэрэглэгчид болон хяналт тавих талуудын хувьд ил тод байдлыг хангаж, системийн тогтвортой ажиллагааг баталгаажуулах боломжтой болно. Ерөнхийдөө, цахим ил тод байдлын индекс нь тус үнэлгээтэй харьцуулахад илүү өргөн хүрээний цогц үнэлгээ юм. Мөн шалгуур үзүүлэлт, түүнийг тооцох аргачлал нь ялгаатай бөгөөд илүү бодит онооны системийг санал болгодог.

2. Үр дүн

2.1. Нэгдсэн үр дүн

2024 оны төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудын цахим ил тод байдлын индекс 69% болж, өмнөх оны үр дүнтэй харьцуулахад 3.8%-аар (65.2%) өсөж, “хангалттай” түвшинд байна.

Энэ өсөлт нь нээлттэй мэдээллийн бүрэлдэхүүн хэсэг өссөнтэй шууд холбоотой. Нээлттэй мэдээллийн хэсэг өмнөх оноос 5.3% -аар өссөн нь энэ оны цахим ил тод байдлын өсөлтөд голлох нөлөө үзүүлсэн хүчин зүйл болсон байна. Сүүлийн гурван жилийн хугацаанд эрх зүйн орчин болон байгууллагын чадамж тогтвортой өссөн ч, нээлттэй мэдээллийн хэсэг хууль эрх зүйн шинэчлэлттэй холбоотойгоор бууралттай байсан. Харин 2024 онд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт сайжирсан нь олон цахим хуудас дээр ажиглагдсан ба хууль хэрэгжиж эхэлснээс даруй хоёр жилийн дараа мэдээллүүд бүрэн орж сайтын ажиллагаанд эерэг нөлөөгөө үзүүлж байна.

Тус үр дүн нь төрийн байгууллагуудын цахим үйлчилгээ, ил тод, нээлттэй байдал зэрэгт гарсан ахиц дэвшлийг илтгэж байгаа бөгөөд засгийн газрын болон орон нутгийн захиргааны байгууллагуудын цахим засаглалыг сайжруулахад чиглэсэн хүчин чармайлтууд


тодорхой хэмжээнд үр дүнгээ өгч байгааг харууллаа.

Гэвч үнэлгээнд хамрагддаг байгууллагуудын 38% нь цахим ил тод байдал ‘сул’ түвшинд байсаар байна. 2019 онд төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын индекс болгон аргазүйгээ өргөжүүлэн хэмжиж эхлэх үед нийт байгууллагын 36% нь л “хангалттай” түвшинд үнэлэгдэж байсан бол 2024 онд энэ хувь хэмжээ 60% болж, 24%-аар өсжээ. Энэ нь мэдээллийн ил тод байдал, иргэдэд хүрэх хүртээмжийг сайжруулах чиглэлд тодорхой ахиц гарсныг илтгэж байна.

2023 онд хангалттай түвшинд үнэлэгдсэн байгууллага нийт байгууллагын 53%-ыг эзэлж байсан ба 2024 онд 7 байгууллага сул түвшнээс хангалттай түвшин рүү шилжсэн байна. Сүүлийн 5 жилийн дунджаас харахад жилд 5-8 байгууллага сул түвшнээс хангалттай түвшинд шилждэг байна. Гэсэн хэдий ч, үлдсэн 38% нь “сул” түвшинд үнэлэгдсэн байгаа нь цахим ил тод байдлын тулгамдсан асуудал, сайжруулах шаардлагатай газрууд байгааг харуулж байна. Эдгээр байгууллагууд нь байгууллагын чадамж, иргэдтэй харилцах механизм, нээлттэй мэдээлэл дээр тусгайлан анхаарах шаардлагатай хэвээр байна.

ЗУРАГ 5

Байгууллагуудын ил тод байдлын түвшинд эзлэх хувь




2.1.1. Цахим ил тод байдлын өөрчлөлт

IRIM судалгааны хүрээлэн нь 2010 оноос эхлэн төрийн байгууллагын цахим мэдээллийн ил тод байдлыг хэмжиж эхэлсэн бөгөөд 2014 оноос хойш тасралтгүй жил бүр үнэлсээр ирсэн. 2019 оноос эхлэн шинэ арга зүй боловсруулан, цахим ил тод байдлын индексийг илүү нарийвчлалтай хэмждэг болсон нь төрийн цахим ил тод байдлын хөгжлийг тодорхойлох, иргэдэд нээлттэй мэдээллийг дамжуулахад тодорхой хувь нэмрээ оруулж байгаа үнэлгээ юм.

Үнэлгээний ажлыг хэрэгжүүлснээс хойш арван гурван жилийн хугацаанд төрийн байгууллагуудын цахим хуудасны мэдээллийн агуулга, хүртээмж бага багаар сайжирдаг боловч зарим жилүүдэд буурдаг. Үүнийг оноор нь тодруулан харвал сонгууль болж, засгийн газрын бүтцэд өөрчлөлт орсноор цахим ил тод байдалд нөлөө үзүүлдэг нь ажиглагдсан.

ЗУРАГ 6

Цахим ил тод байдлын өөрчлөлт, оноор



2024 оны төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын индекс 69% болж, өмнөх оноос 3.8%-аар (65.2%) өсөж, “хангалттай” түвшинд байгаа нь сүүлийн 3 жил дэх хамгийн өндөр өсөлт болсон.

Сүүлийн 5 жилийн туршид цахим ил тод байдлын индекс жил бүр 2.5%-3%-аар өсөж байгаа нь тогтвортой өсөлттэй байгааг харуулж, 2023 онд цахим ил тод байдлын индекс анх удаа

сул түвшнээс ‘хангалттай’ түвшин рүү ахисан юм. Сүүлийн 5 жилийн өсөлтийн түвшнийг (2%-2.5%) тооцоолбол, энэ хандлага хэвээр үргэлжилбэл 2030 онд цахим ил тод байдлын индекс 85% орчимд хүрч, “сайн” түвшинд үнэлэгдэх боломжтой. Энэ нь төрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, засаглалын ил тод байдал, хариуцлагын түвшнийг улам сайжруулахад чухал нөлөө үзүүлэх юм.

¹ Бүрэлдэхүүн тус бүрийн индекс дэд бүрэлдэхүүний нийлбэрээр тодорхойлогдоно.

2.2. Бүрэлдэхүүн тус бүрийн үр дүн

2024 оны үнэлгээ нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль шинэчлэгдэж гарснаас хойш хийгдэж буй гурав дах удаагийн үнэлгээ юм. Энэ нь цахим ил тод байдлын өөрчлөлтийг сүүлийн гурван жилээр хэмжиж харах боломжийг олгож байна.

ЗУРАГ 7

Цахим ил тод байдлын нэгдсэн үр дүн, бүрэлдэхүүн тус бүрээр



2.2.1. Бүрэлдэхүүн 1: Мэдээллийг ил тод болгох бодлогын орчны индекс

Энэ Мэдээллийн цахим ил тод байдлыг хэрэгжүүлэх, сайжруулахад бодлогын орчны дэмжлэг, тогтолцоо суурь шинжтэй буюу тэргүүлэх ач холбогдолтой тул энэхүү бодлогын орчин хэр бүрдсэн бэ гэдэгт анхаарах нь зүйтэй. Бодлого, зохицуулалтын орчны ил тод байдлыг ханган ажиллах боломж нөхцөлийг хэр хангасныг олон улс, үндэсний болон байгууллагын түвшинд нарийвчлан үнэлсэн. Энэ бүрэлдэхүүн хэсгийн үр дүнг олон улсын түвшинд гарч буй засаглалын ил тод байдлын үзүүлэлтүүд болон үндэсний ба байгууллагын түвшинд гэсэн гурван түвшинд мэдээллийн цахим ил тод байдлыг хангах чиглэлээр батлан хэрэгжүүлж буй бодлого,

журамд үндэслэн индекс тооцдог. Бодлогын орчны индекс нь эдгээр гурван түвшний үзүүлэлтүүдийн нийлбэрээр тооцогдоно. Бодлогын орчин 'хангалттай' (79.5) түвшинд үнэлэгдсэн. Энэ үр дүнг 2023 оны үр дүнтэй харьцуулахад (79.2%) бага зэрэг буюу 0.3%-аар өссөн үзүүлэлт юм. Үр дүнг бодлогын орчинд хамаарах дэд 5 бүлгээр задлан үзэхэд бүгд ахисан үзүүлэлттэй байна. Энэ нь 2022 оноос шинэ хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2023 онд байгууллагуудын шинэ хуулийн дагуу нийцүүлэн гаргасан дотоод дүрэм журмын шинэчлэл хийгдэх үйл явц үргэлжилж байгаа нь

ээрэг үр дүн гарахад нөлөөлжээ гэж дүгнэж болох юм. Бодлогын орчны үнэлгээг дэд бүрэлдэхүүн тус бүрээр задлан харвал дараах үр дүн харагдаж байна.

Хүснэгт 2

Бодлогын орчны индекс

Дэд бүрэлдэхүүн	2023 оны индекс	2024 оны индекс	Өөрчлөлт
Бодлогын орчин	79.2%	79.5%	+0.3%
Олон улс			
Мэдээлэл авах эрх	27.0%	29.3%	+2.3%
Засаглал	16.0%	17.3%	+1.3%
Иргэний нийгэм	23.0%	19.2%	-3.8%
Улс			
Үндэсний бодлого, зохицуулалт	12.0%	12.3%	+0.3%
Байгууллага			
Байгууллагын бодлого зохицуулалт	1.2%	1.4%	+0.2%

Энэ жилийн тухайд Иргэний нийгмийн үзүүлэлтээс бусад үзүүлэлтүүд өсөлттэй байгаа бол иргэний нийгмийн үзүүлэлт сүүлийн 2 жилийн хугацаанд байнгын буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь төрөөс иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах, хянах зорилгоор хэт нарийн хууль, дүрэм, журмыг нэвтрүүлэх оролдлогуудыг хийж, цаашлаад ИНБ-уудын санхүүжилт, үйл ажиллагааны эрх чөлөөнд нөлөөлж байгаа. Тухайлбал, ТББ-ын тухай хуулийн шинэчлэл болон ил тод байдлын шаардлагууд нь иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааны санхүүжилт болон оролцоог бууруулах эрсдэл үүсгэсэн. Мөн Иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаанд улс төрийн оролцоо, дарамт нэмэгдэх нь тэдний хараат бус байдалд сөргөөр нөлөөлөх, засаглалын ил тод байдал, авлигын хяналт сул байгаа нь иргэний нийгмийн байгууллагуудын үр нөлөөнд иргэдийн итгэлийг бууруулах, эдийн засгийн хүндрэл, иргэдийн амьдралын чанар муудаж байгаа нь иргэдийн идэвхийг бууруулж, иргэний нийгмийн үйл ажиллагаанд оролцох сонирхолгүй болгох зэрэг нь сөргөөр нөлөөлөх шалтгаан болж байна.

Олон улсын түвшний үзүүлэлтүүдийг Мэдээлэл авах эрх, Засаглал, Иргэний нийгэм гэсэн гурван дэд бүрэлдэхүүний хүрээнд (i) энэ чиглэлд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, (ii) Монгол Улс хамрагдсан 9 индексээс эх сурвалж болгон үр дүнг тооцсон. Үр дүнд Монгол Улсын цахим ил

тод байдлыг үнэлж буй олон улсын индексүүд “хангалттай” түвшинд буюу индекс тус бүрийн үнэлгээнүүд 80%-аас дээш хувьтай үнэлэгдэж байна.

Мэдээлэл авах эрхийн болон засаглалын үзүүлэлтүүдийг тооцох индексүүд бага зэрэг ахисан болон өмнөх үр дүнгээ хэвээр хадгалсан байгаа нь эдгээр үзүүлэлтүүд бага зэрэг өсөхөд нөлөөлсөн. Тухайлбал, олон улсын индексүүдийн 2024 онд шинэчлэгдсэн үр дүнг авч үзвэл 2022 онтой харьцуулахад Rule of Law Index-д 62 дугаар байрнаас 64 дүгээр байрт буюу 2 байр ухарсан бол Freedom House Index-д 55 дугаар байраа хадгалсан байна. Мөн Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтээс тооцдог 4 үзүүлэлтийн дундаж 45%-тай байна.

Харин иргэний нийгмийн үзүүлэлт бодлогын орчин гэх бүрэлдэхүүнээс цор ганц буурсан үзүүлэлт болж байна. World Press Freedom Index-д 88 дугаар байрнаас 8 оноогоор буурч, 2024 онд 109-р байрт орж эрэмбэ хойшилжээ. Мөн CIVICUS байгууллагын иргэний орон зайн үзүүлэлтийг тооцдог үнэлгээгээр 2024 онд өмнөх үнэлгээнээс 7 оноогоор буурч иргэний орон зай “нарийссан” гэсэн ангиллаас “саадтай” ангилал руу бууруулжээ. Буурсан гол шалтгаан нь хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгслээр дарангуйлж, тайван жагсаал цуглаан хийх арга хэмжээнээсээ ухарч байгаа хэмээн тодотгосон байна. Хэдийгээр E-Government Development Index (2024 EGD) –ийн ерөнхий үзүүлэлтээр 193 улсаас 46-т орон

28 байраар ахисан, иргэний нийгмийн үзүүлэлт тооцдог EGD-ийн цахим оролцооны индексээр 0.7808 оноо авч, 193 орноос 37-р байрт орсон нь 2022 оны 57-р байраас 20 байраар ахисан үзүүлэлттэй байна. Эдгээр ахиц нь Монгол Улсын цахим засаглалын хөгжилд томоохон

дэвшил гарсныг харуулж байгаа ч мэдээлэл авах эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийн үзүүлэлтүүд бууралттай үнэлэгдсэн нь ЦИТБИ-ийн энэхүү дэд бүрэлдэхүүн бууралттай байхад нөлөөлж байна. Ашигласан эх сурвалжийн хураангуйг Хүснэгт 3-т харуулав.

ХҮСНЭГТ 3

Бодлогын орчны хүрээнд хамруулсан олон улсын индексүүд

Индексүүд	Гаргасан байгууллага	Гарсан он	Монгол Улсын эрэмбэ	Хамрагдсан улсын тоо
Right to Information (RTI) Rating	Centre for Law and Democracy	2024	64	136
Rule of Law Index	World Justice Project	2024	66	142
World Governance Indicators (WGI)	World Bank	2024	68	214
Bertelsmann Transformation Index (BTI)	Bertelsmann Stiftung	2022	26	137
Freedom House Index	Freedom House	2024	55	210
World Press Freedom Index	Reporters without borders	2024	109	180
Civic space ratings	CIVICUS	2024	83	198
Varieties of Democracy (V-Dem)	V-Dem Institute	2022	121	179
E-Government Development Index - E-Participation	United Nations	2024	37	193

Үндэсний түвшний дэд бүрэлдэхүүнд Монгол Улсын урт болон дунд хугацаанд баримтлах хөгжлийн баримт бичиг, мэдээллийн ил тод байдлыг хангахтай холбоотой батлагдсан хууль, тогтоомж болон түүнийг даган гарсан журмуудыг хамруулан авч үзсэн. Үр дүнд нь эдгээр баримт бичгүүдэд мэдээллийн ил тод байдлыг хангахтай холбоотой агуулга ‘хангалттай’ орсон.

Урт болон дунд хугацааны хөгжлийн баримт бичгүүдэд тус бүрдээ энэ төрлийн агуулгыг зорилт хэлбэрээр тодорхойлж, хоорондын уялдаа сайтар хангагдсан. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт мэдээллийн ил тод байдлыг сайжруулах чиглэлээр дараах зорилтуудыг тусгасан байна:

- Цахим засаглалыг хөгжүүлэх: Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд хүртээмжтэй, шуурхай үйлчилгээ үзүүлэх замаар төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах.
- И-Монголиа нэгдсэн системийг өргөжүүлэх: Төрийн бүх үйлчилгээг нэг цонхны бодлогоор хүргэх “И-Монголиа” системийг сайжруулж, иргэдийн мэдээлэл авах, үйлчилгээ авах үйл явцыг хялбаршуулах.

- Авлигын эсрэг тэмцэл, шударга ёсыг бэхжүүлэх: Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих механизмыг сайжруулах.
- Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх: Төрийн бодлого, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог хангах, мэдээлэл солилцоог сайжруулах замаар ил тод, нээлттэй засаглалыг бэхжүүлэх.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 2021 оны 12 дугаар сарын 17-нд батлагдан, уг хуулийг даган гарахаар тодорхойлогдсон 12 журам 2022 онд батлагдан хэрэгжиж байна. Эдгээрээс Нээлттэй өгөгдлийн жагсаалт гаргах журмаар төрийн 70 байгууллагын 606 нээлттэй өгөгдлийг олон нийтэд ил тод байршуулах шийдвэр гаргасан. Журмын хэрэгжилтүүдээс “Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам” болон “Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системийн үйл ажиллагааны журам”-уудын хэрэгжилт маш сайн хангагдаж байгаа бол “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ийн хэрэгжилт сул байна.

МУЗГ-аас энэ мэт олон бодлого, журмуудыг батлан, хэрэгжүүлж байгаа боловч цаашид иргэдэд төрийн мэдээллийг нэг цонхоор хүргэх, төрийн байгууллагуудын цахим хуудсыг нэг загвар, стандарттай болгох ажлыг ЦХИХХЯ-аас 2024 онд эхлүүлж, 4693 цахим хуудсыг gov.mn-д нэгтгэсэн. Энэ нь иргэдэд мэдээллийг илүү хүртээмжтэй, ойлгомжтой хүргэснээр зардал хэмнэх зорилготой.

Байгууллагын түвшний дэд бүрэлдэхүүнд мэдээллийн ил тод байдлыг хангах байгууллагын дотоод зохицуулалттай холбоотой 8 үзүүлэлтээр үнэлэхэд 98 байгууллагаас 55 байгууллага нь буюу 56% нь мэдээлэл авах эрхийг хангах хууль, түүнийг даган гарсан журмуудын хүрээнд байгууллага дотооддоо зохицуулалтаа хангах баримт бичиггүй буюу албан ёсны цахим хуудастаа байршуулаагүй байна. Үлдсэн 43 байгууллагын хувьд дотоод зохицуулалт бүхий баримт бичигтэй цахим хуудсандаа байршуулсан хэдий ч хэрэгжүүлэх субъектийг тодорхойлох, боломжит нөөцөөр хангах болон хяналт тавих механизмын талаарх агуулга тусаагүй байна. Байгууллагын түвшинд дунд хугацааны бодлогын баримт бичгүүддээ цахим мэдээлэл болон мэдээллийн ил тод байдлыг хангахтай холбоотой заалт дийлэнх байгууллагад туссан боловч ерөнхий байдлаар тусгажээ. "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль"-н зохицуулалттай холбоотойгоор дотоод журмаа

сүүлийн жилүүдэд шинэчилсэн, хууль болон дагалдах журмуудад дурдсан агуулгууд бүрэн орж тусгагдсан болоод мэдээллийн ил тод байдлыг хангах дотоод үйл явцын тогтвортой байдлыг хангах үзүүлэлтүүдийн хүрээнд үнэлэхэд 8.2% нь л эдгээр агуулгуудыг хангалттай түвшинд тусгасан байна. Энэ үр дүнг өмнөх жилтэй харьцуулахад 6 байгууллага байсан бол нэмж хоёр байгууллага мэдээллийн ил тод байдлыг хангахтай холбоотой журмыг шинээр батлан, нийтэлсэн гэсэн үг юм. Хангалттай түвшинд үнэлэгдсэн байгууллагуудыг дурдвал:

1. Батлан хамгаалах яам
2. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар,
3. Үндэсний статистикийн хороо,
4. Гадаад харилцааны яам,
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар,
6. Архивын ерөнхий газар
7. Боловсрол шинжлэх ухааны яам
8. Ойн газрын журмууд байв.

Мэдээллийн цахим ил тод байдлыг хангах талаар байгууллагууд дотооддоо дүрэм, журам, тушаал гаргахдаа мэдээллийн цар хүрээг тодорхойлох, мэдээллийг ангилах, мэдээллийг бэлтгэх, хариуцагчийн тодорхойлох, нийтлэгчдийн эрх, үүргийг тодорхойлж шинэчлэгдэх хугацаа болон хэрэгжилтэд хяналт тавих механизмыг тодорхой тусгах нь үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

2.2.2. Бүрэлдэхүүн 2: Төрийн байгууллагын мэдээллийг ил тод болгох чадамж, бэлэн байдлын индекс

Тухайн байгууллагын ил тод байдлыг бий болгоход мэдээллийг тасралтгүй нийлүүлэх, мөн мэдээллийн үйл явцыг зохион байгуулах чадамж, бэлэн байдал нь чухал хүчин зүйл болдог.

Иймд жил бүр байгууллагын чадамж хэсгийг үнэлдэг бөгөөд энэ бүрэлдэхүүн хэсгийн мэдээллийн эх сурвалж нь (i) үнэлгээнд хамрагдаж буй тухайн төрийн байгууллагын холбогдох ажилтнаас авдаг анхдагч мэдээлэл, (ii) цахим хуудасны технологийн нийцтэй байдлыг илтгэх үзүүлэлтүүд юм.

2024 оны Байгууллагын чадамжийн хэсэг “хангалттай” (74.6%) түвшинд үнэлэгдсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 1.8%-аар өссөн үзүүлэлт юм. Гэсэн хэдий ч энэ өсөлт нь сүүлийн таван жилийн дундаж өсөлт болох 3.9%-тай харьцуулахад хамгийн бага өсөлттэй жил байлаа. Энэ нь байгууллагын чадамжийн тасралтгүй өсөлтийн хандлагад тодорхой хэмжээнд саад учирсныг илтгэж байна.

Байгууллагын чадамж хэсгийн зарим үзүүлэлтийг тооцох зорилгоор тухайн байгууллагын ил тод байдал хариуцсан

мэргэжилтнээс авдаг асуумжид сүүлийн жилүүдэд байгууллагууд идэвхтэй хамрагдаж байсан. Гэвч 2024 онд Shilen.gov.mn платформд мэдээлэл оруулах тогтолцоо бүрэн нэвтэрснээс үүдэн ижил төрлийн судалгаанд хамрагдах сонирхол багассан хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, 2023 онд нийт 86 байгууллага асуумжид оролцож байсан бол 2024 онд энэ тоо 51 болж буурсан. Энэхүү хандлага үргэлжилж, оролцогчдын тоо цаашид ч буурах эрсдэлтэй байна.

Хүснэгт 4

Байгууллагын чадамж хэсгийн дэд бүрэлдэхүүний индекс

Дэд бүрэлдэхүүн	2023 оны индекс	2024 оны индекс	Өөрчлөлт
Байгууллагын чадамж	72.8%	74.6%	+1.8%
Байгууллагын ил тод байдлыг хангах үйл явц ба нөөц	41.1%	41%	+0.1%
Цахим хуудасны технологийн нийцтэй байдал	15.9%	17.8%	+1.9%
Мэдээлэл, харилцааны технологийн чадавх	15.8%	15.7%	-0.1%

Байгууллагын чадамж хэсгийн бүрэлдэхүүн хэсгүүдийг нарийвчлан авч үзвэл, цахим хуудасны технологийн нийцтэй байдал жил бүр тогтвортой өсөлттэй гарсан. Энэ үзүүлэлт нь тухайн байгууллагын веб сайт технологийн хувьд хэрэглэхэд тохиромжтой эсэхийг үнэлдэг бөгөөд нийт байгууллагын 80% нь вэбсайтын бүтэц хэсгээс бусад бүх үзүүлэлтээ хангаж байна. Вэбсайтын сайжруулалтын үр дүнд иргэд цахим платформыг ашиглан хүнд сурталгүй, хурдан шуурхай, аль ч газраас, ямар ч төхөөрөмжөөс шаардлагатай мэдээллийг авах боломжтой болж, байгууллагын веб сайтууд технологийн хувьд хурдацтай сайжирч байгаа давуу талыг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Харин мэдээлэл холбооны технологийн чадавх болон байгууллагын ил тод байдлыг хангах үйл явцыг хангах хэсэг сүүлийн 5 жилийн

хугацаанд ердөө 2%-ын л өсөлттэй байна. 2022 онд судалгаанд хамрагдсан байгууллагуудын 38% нь цахим ил тод байдлыг бий болгох стратегийн төлөвлөгөө эсвэл хөтөлбөртэй гэж үзсэн бол 2023 онд энэ үзүүлэлт 48%-д хүрчээ. Харин 2024 онд стратегийн төлөвлөгөө эсвэл хөтөлбөртэй гэж хариулсан байгууллагын хувь 51%-д хүрсэн нь өмнөх жилээс ердөө 3%-аар өссөн үзүүлэлт байв. Цахим ил тод байдлыг хангах стратегийн төлөвлөгөө нь мэдээллийг хэрэглэгчдэд хүртээмжтэй, ойлгомжтой байдлаар хүргэх арга замыг тодорхойлж, хэрэглэгчдэд үйлчилгээг хурдан шуурхай хүргэх боломжийг бүрдүүлдэг. Цаашлаад мэдээлэлтэй холбоотой давхардал, хүнд суртлыг бууруулж, зардлыг хэмнэхэд тусалдаг. Иймд төрийн байгууллагууд энэ төрлийн стратеги, төлөвлөгөө хөтөлбөртэй байх нь цахим ил тод байдлыг хөгжүүлэх суурь үзүүлэлт юм.

2023 онд нийт үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудын 65.8% нь мэдээллийг ил тод болгох үүрэг бүхий хариуцсан ажилтан болон алба, нэгжтэй байсан бол 29.3% нь энэ үүргийг хавсран гүйцэтгэдэг, 4.9% нь мэдээллийг ил тод болгох үүрэгтэй ажилтан байхгүй эсвэл байгаа эсэх нь тодорхойгүй гэж хариулсан байна. Харин энэ жилийн хувьд, мэдээллийг ил тод болгох үүрэг бүхий хариуцсан ажилтан болон алба, нэгжтэй эсвэл хавсран гүйцэтгэдэг байгууллагуудын тоо өмнөх жилийнхтэй төстэй хэвээр байгаа ч, мэдээллийг ил тод болгох үүрэгтэй ажилтан байхгүй гэсэн хариулсан байгууллагууд огт байхгүй болж, сайжирчээ. Энэ нь байгууллагууд Shilen.gov.mn платформд мэдээллээ оруулдаг болсонтой холбоотойгоор бүх байгууллага мэдээллийн хариуцагчтай болсон гэж үзэж болохоор байна.

Мэдээллийг олон нийтэд ил тод болгохын хэрээр өгөгдлийн чанар, хамгаалалт, аюулгүй байдал чухал үүрэгтэй. Эдгээр үүргийг гүйцэтгэхэд зөвхөн хүний нөөц бус, мөн өндөр өртөгтэй тоног төхөөрөмж, программ хангамж, аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэх төсөв шаардлагатай.

Өмнөх онд мэдээллийг ил тод болгохтой холбоотой төсөв, хөрөнгө төрийн байгууллагуудын 62%-д нь тодорхой хэмжээнд суулгадаг гэж хариулж байсан бол 2024 онд 65% болж өссөн. Гэвч дээрх төсөв нь дийлэнх байгууллагад буюу 70% нь хүрэлцээгүй байдлыг илэрхийлсэн байна. Сүүлийн таван жилийн хугацаанд тухайн байгууллагын цахим ил тод байдлын индексийн өсөлт болон төсвийн хүрэлцээтэй байдлын хариултыг харьцуулан харвал индекс өсөж байгаа хэдий ч төсөв хүрэлцдэггүй гэсэн санал хүсэлт хэвээр байна.

Байгууллагын чадамж хэсэгт 2024 онд онцгой анхаарах зүйлсийн нэг Серверийн аюулгүй байдлыг хангадаг зохицуулалттай болсон байгууллагын эзлэх хувь өмнөх 2 жилийн үр дүнгээс даруй 10%-аар нэмэгдсэн явдал байлаа. Төрийн байгууллага нь иргэдийн хувийн

мэдээлэл, нууц баримтуудыг хадгалдаг тул эдгээр өгөгдлийг хамгаалах нь төрийн хариуцлага, итгэл үнэмшилд нөлөөлдөг.

2024 оны 1-р сард Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас Кибер аюулгүй байдлын төлөвлөлтийн загвар стандарт-2024 нэрт семинарыг олон улсад хэрэгждэг стандарт, баримт бичгийг танилцуулах зорилгоор зохион байгуулсан байна. Энэхүү семинарт төрийн захиргааны онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага, их дээд сургуулийн кибер аюулгүй байдлын асуудал хариуцсан нийт 100 гаруй албан хаагч оролцсон байна.

Байгууллагын цахим ил тод байдлын гүйцэтгэлийг тогтмол хянаж, үнэлэх нь жил бүрийн хамгийн бага гардаг үзүүлэлтүүдийн нэг юм. Энэ нь байгууллагын улирал болон жилийн эцсийн үнэлгээнд мэдээллийн цахим ил тод байдлыг бий болгохтой холбоотой үнэлгээ тусгагдаагүй, мөн гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт болон стратеги батлагдаагүйтэй холбоотой байсныг өмнөх жилүүдэд дурдсан байсан. Харин энэ жил Засгийн газрын шилэн ажиллагаатай холбоотойгоор судалгаанд хамрагдсан байгууллагын 61% нь цахим ил тод байдлынхаа гүйцэтгэлийг тогтмол хянаж, үнэлдэг болсон гэж хариулсан байна. Энэ нь өнгөрсөн жилтэй харьцуулахад мөн 10%-аар өссөн үзүүлэлт юм. Дараагийн анхаарах асуудал бол цахим хуудасны мэдээллийн шинэчлэлтэй холбоотой. Нийт байгууллагуудын 90%-с дээш нь цаг үеийн шинэ мэдээ, мэдээллийг тогтмол оруулж байгаа нь сайшаалтай ч, хүний нөөцийн мэдээллүүд шинэчлэгддэггүй, мөн шинэчлэлийг харуулсан баримт байдаггүй. Төсөв санхүүтэй холбоотой мэдээллийг шилэн данс руу орж он болон улирлаар харах боломжтой байдаг бол хүний нөөцийн мэдээллийн шинэчлэлийг харах боломжгүй. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд мэдээллийн шинэчлэлийг харуулах нотлох баримт заагаагүй учир, тухайн мэдээлэл хэзээ шинэчлэгдсэн талаарх мэдэх боломжгүй байдал нь жил бүрийн үнэлгээнд

тулгардаг гол бэрхшээл юм. Хүний нөөцийн шинэчлэгдсэн мэдээлэл нь иргэд, олон нийтэд байгууллагын бүтэц, ажилтнуудын байдал, үүрэг хариуцлагыг тодорхой харуулах боломжийг олгодог. Хүний нөөцийн мэдээллийг тогтмол шинэчилж, зарим албан тушаалын орон тоо, томилгоо, хөдөлгөөн гэх мэт мэдээллийг байнга гаргахад байгууллагын гүйцэтгэл ил тод болох, хяналт тавихад тусалдаг.

Өнгөрсөн жилүүдтэй харьцуулахад өөрчлөлт ороогүй үзүүлэлтүүдийг дурдвал,

- Дотоод болон гадаад үнэлгээ нь дээр тулгуурласан дижитал ил тод байдлыг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах,
- Мэдээлэл холбоо технологийн (МХТ) болон цахим ил тод байдлыг сайжруулах чиглэлийн сургалтууд авах,
- Веб сайт руу хандсан хандалтын тоог цахим ил тод байдлыг сайжруулах төлөвлөгөө, үр дүн зэрэгт ашиглах байдал,
- Байгууллагад тогтмол шинэчлэгдэж байдаг нээлттэй мэдээллийн сан зэрэг үзүүлэлтүүд байна.

Өөрөөр хэлбэл эдгээр үзүүлэлтүүдийн өөрчлөлтгүй байдал нь байгууллагын чадамж хэсгийн өсөлтийг зогсооход гол нөлөө үзүүлж байна.

Вэбсайтын хандалтын тоон мэдээллийг ашиглах нь байгууллагуудын дижитал стратеги, хэрэглэгчдийн хандлагыг ойлгох чухал хэрэгсэл болдог. Хандалтын тоо нь цахим ил тод байдлын хэрэгцээг тодорхойлж, шаардлагатай өөрчлөлт, сайжруулалтыг хийхэд үндэслэл болохуйц үнэ цэнтэй мэдээллийг өгдөг.

Асуулгын үр дүнд төрийн захиргааны 98 байгууллагын ердөө 27% нь вэбсайтынхаа хандалтын тоог ил тод харуулдаг болох нь тогтоогдсон. Үүнээс гадна хандалтын мэдээлэл харагдахуйц байгаа ч бүх утга нь "0" гэж заасан, хандалтын тоо ажиллахгүй байгаа 4 байгууллага илэрсэн.

Төрийн байгууллагуудын дунд хамгийн өндөр хандалттай сайт нь Үндэсний статистикийн газар

байсан бөгөөд өдөрт 2,641 хүн, сард 82,378 хүн хандаж байна. Энэ нь статистикийн мэдээлэл олон нийтэд өндөр эрэлттэй, хэрэглээтэй байгааг харуулж байна. Хоёрдугаарт Цагдаагийн ерөнхий газар орсон бөгөөд өдөрт 1,400 хүн тус вэбсайтад ханддаг. Үүний дараа Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар зэрэг байгууллагууд багтаж байна. Харин хамгийн бага хандалттай сайтууд нь аймгуудын вэбсайт байгаа нь анхаарал татахуйц үзүүлэлт юм.

Судалгааны явцад зарим вэбсайтын хандалтын тоо үнэн зөв биш байж болзошгүй нь ажиглагдсан. Жишээлбэл, Увс аймгийн вэбсайт өдөрт 793,290 хандалттай гэж заасан ч долоо хоногийн хандалт нь мөн 793,290 гэж харагдаж байгаа нь системийн алдаа байж болзошгүйг харуулж байна.

Нэмж хэлэхэд, төрийн байгууллагууд хандалтын мэдээллийг харуулах форматын хувьд харилцан адилгүй байна. Зарим сайт өдөр, сар, жилийн хандалтыг харуулдаг бол, зарим нь зөвхөн долоо хоног, нийт хандалтын тоог үзүүлдэг. Эсвэл монгол хэл дээр тохируулсан хэдий ч дөрвөн төрийн байгууллагын вэбсайт хандалтын мэдээллийг зөвхөн англи хэл дээр харуулж байна. Энэ нь цахим ил тод байдлын хүртээмжид сөрөг нөлөө үзүүлж, мэдээлэл авахад хүндрэл учруулж болзошгүй.

Вэбсайтын хандалтын тоог цахим нээлттэй байдлын өсөлт, хэрэглэгчдийн мэдээлэл авах хандлагыг тодорхойлох чухал үзүүлэлт гэж үзэж болох ч төрийн байгууллагуудын ердөө 27% нь л хандалтын мэдээллийг нээлттэй харуулж байна. Цаашид төрийн байгууллагууд хандалтын мэдээллийг илүү стандартчилах, найдвартай ажиллаж байгаа эсэхийг хянах, мэдээллийн үнэн зөв байдлыг баталгаажуулах шаардлагатай байна. Одоогийн нөхцөл байдлаас харахад хандалтын мэдээллийг шууд ашиглах нь нарийвчлал, нэгдмэл байдал хангалтгүй байгаа тул судалгааны үндэслэл болгон ашиглахад эрсдэлтэй хэвээр байна.

2.2.3 Бүрэлдэхүүн 3: Мэдээллийн цахим нээлттэй байдлын индекс

Энэ бүрэлдэхүүн хэсэгт төрийн байгууллагуудын цахим хуудсаар ил болгож буй нээлттэй мэдээллүүд нь хуульд тогтоосон хугацааны дагуу цахим хуудаст байршиж байгаа эсэхийг тодруулна. Ингэхдээ төрийн байгууллагын цахим хуудсаараа нийтэлж буй мэдээллийн агуулга нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан 'нээлттэй мэдээлэл'-ийг хамрах ба хуульд хэр нийцэж байгаад төвлөрнө. Мөн Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад дүрэм журамтай уялдана. Мэдээллийн цахим нээлттэй байдал 'сул' (52.8%) түвшинд үнэлэгдсэн байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль батлагдсанаар цахим нээлттэй байдлын индекс сүүлийн хоёр жилд буурч байсан бол энэ жилийн хувьд өмнөх онтой харьцуулахад 5.3%-аар өсжээ. Хууль батлагдахаас өмнө энэ бүрэлдэхүүн хэсэг нь сул түвшинд үнэлэгддэг байсан бол хууль батлагдсанаар хангалтгүй түвшин рүү буурсан. Харин 2024 онд дахин түвшин ахиж, сул түвшинд үнэлэгдэх болсон нь нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт төрийн байгууллагуудын түвшинд хэрэгжилт тогтворжиж байгааг илтгэж байна. Үүнийг дэд бүрэлдэхүүн тус бүрээр задлан харвал дараах үр дүн харагдаж байна.

Хүснэгт 5

Цахим мэдээллийн нээлттэй байдлын индекс

#	Дэд бүрэлдэхүүн	2023 оны индекс	2024 оны индекс	Өөрчлөлт
1	Цахим мэдээллийн нээлттэй байдал	47.5%	52.8%	+5.3%
2	Нээлттэй мэдээлэл	42.0%	46.7%	+4.7%
3	Харилцаа холбоо ба эргэх холбоо	5.8%	6.2%	+0.7%

Нээлттэй мэдээлэл

Нээлттэй мэдээлэл хэсэгт 5 дэд бүрэлдэхүүн хэсгийн хүрээд нээлттэй мэдээллийг шалгадаг. Нээлттэй мэдээллийн хэсэг сүүлийн жилүүдэд өсөлт зогсонги байсан ба энэ жилийн хувьд өмнөх оноос 4.7%-аар өссөн байна.

Дэд бүрэлдэхүүн тус бүрээр нь үр дүнг тоймловол:

Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал

Энэхүү хэсэгт тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуульд заасан нээлттэй мэдээллүүд веб сайтад байршсан эсэхийг үнэлдэг. Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, байгууллагын чиг үүрэг бүтэц зохион байгуулалт, хаяг байршлын мэдээлэл бүх байгууллагад харьцангуй жигд сайн байршсан байна.

Өнгөрсөн гурван жилээс хамгийн их өсөлт үзүүлсэн үзүүлэлтүүд болох хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний

тайлан, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан, үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт зэргүүд нь нийт байгууллагын 80%-аас дээш сайтуудад байршсан байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн эхний жилд энэ үзүүлэлт 50%-тай байв.

Гэвч өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тайлан мэдээ нь хамгийн бага оноотой үзүүлэлт болсон байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.2.8-т өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг ил тод байлгахыг тусгасан. Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тайлан мэдээг нээлттэй байлгах нь олон нийтийн итгэл, эрх зүйн хариуцлага, харилцааны хүртээмжийг хангах чухал ач холбогдолтой. 2024 оны хувьд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь өргөдөл, гомдол, шийдвэрлэлтийн


нэгдсэн тайлангаа нийтэлсэн байдал нь жишиг байгууллагаар онцолж байна.

Хүний нөөцийн ил тод, нээлттэй байдал

Хүний нөөцийн ил тод байдлын хэсэгт ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл, албан хаагч ажилтныг сонгон шалгаруулах журам, албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм бүх байгууллагад харьцангуй жигд сайн байршсан байна.

ЗУРАГ 8

Хүний нөөцийн ил тод байдлын жишээ



Сүүлийн гурван жилд хамгийн их өсөлттэй үзүүлэлтүүд нь хүний нөөцийн стратеги болон стратегийг хэрэгжилтийг хянаж үнэлэх журмын үзүүлэлт байна. Энэ үзүүлэлт нийт байгууллагын 61% нь байршсан бөгөөд нийтийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилтийн эхний жилд энэ үзүүлэлт 49%-тай байсан.

Хэдийгээр сул орон тооны талаарх мэдээлэл, сонгон шалгаруулах журам, ёс зүйн дүрэм, хүний нөөцийн гүйцэтгэлийг үнэлэх журмууд хангалттай хэмжээнд байршиж байгаа хэдий ч цаашид хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийг илүү нарийвчлан оруулах шаардлагатай байна. Тухайлбал, төрийн албан хаагчдад олгогдож буй нийгмийн баталгааны хөтөлбөрүүд, албан хаагчдын сургалт, хөгжлийн хөтөлбөр, мэргэшлийн үйл ажиллагааг тайлагнах, албан тушаалын тодорхойлолт, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах зар, сонгон шалгаруулалт, ярилцлага болон шийдвэр гаргалттай холбоотой мэдээллүүдийг тус тус байршуулах шаардлагатай. Яамдын хувьд энэ үзүүлэлтийн хэрэгжилт хангалттай


түвшинд байгаа ба Эрүүл мэндийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Сангийн яам гурав энэ үзүүлэлтээрээ тэргүүлж байна.

Хүний нөөцийн удирдлагын үйл явц, шийдвэр гаргалт болон хяналтын тогтолцоо нээлттэй байх нь байгууллагын үйл ажиллагааг хянах боломжийг олгож, түүний үйл ажиллагаанд ил тод байдал, хариуцлага бүхий хяналт үүсгэдэг. Иймээс төрийн захиргааны байгууллагууд хүний нөөцийн удирдлагын ил тод байдалтай холбоотой мэдээллээ оруулах нь олон нийттэй харилцах, шударга ёс, хариуцлагатай засаглал, иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, авлигын эсрэг тэмцэх зэрэг чухал зорилгод хүрэхэд тусалдаг. Төсөв санхүү худалдан авах ажиллагааны талаарх ил тод, нээлттэй байдал

“Шилэн дансны тухай” хууль нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн зарцуулалт, төсвийн орлого, зарлагын мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй байлгах зорилготой.

ЗУРАГ 9

Санхүүгийн ил тод байдлын жишээ



Төрийн захиргааны байгууллагууд энэхүү хуулийн дагуу өөрсдийн цахим хуудсанд “Шилэн данс” гэсэн тусгай цэс нээж, дараах мэдээллийг нийтлэх үүрэгтэй:

- Төсөв, гүйцэтгэл: Улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт зэрэг мэдээлэл,
- Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт: Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, тендерийн зар, худалдан авалтын мэдээлэл,
- Бусад: Томилолтын зардал, хандив, тусламжийн зарцуулалт зэрэг мэдээлэл, Эдгээр мэдээллийг тогтмол шинэчилж, олон нийтэд нээлттэй байлгах нь төрийн

байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангахад чухал үүрэгтэй.

Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл, төсвийн гүйцэтгэлийн биелэлт, хагас бүтэн жилийн санхүүгийн тайлан, нэгдсэн төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ, төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгаан гэх мэдээллүүд бүх байгууллагад жигд сайн байршсан байна.

Үнэлгээнд хамгийн бага үзүүлэлт нь аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл хэсэг байна. “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн 8.4.9-д зааснаар төрийн байгууллагууд аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг өөрсдийн цахим хуудсанд нийтлэх үүрэгтэй. Гэсэн хэдий ч, зарим байгууллагууд энэ үүргээ бүрэн биелүүлдэггүй, мэдээллийг цаг тухайд нь байршуулахгүй байх, эсвэл огт нийтлэхгүй байх тохиолдлууд гарч байна. 2023 онд дээрх үзүүлэлтийг нийт байгууллагын 45% нь оруулсан бол 2024 онд 3%-аар нэмэгдсэн байна. Энэ оны хувьд Зам тээвэр хөгжлийн яам аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг жишиг байдлаар нийтэлснийг онцолж байна. Дараагийн хамгийн бага үзүүлэлттэй хэсэг нь санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт хэсэг юм. Төрийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээг хуулийн хугацаанд цахимаар ил тод болгож, иргэдэд нээлттэй хүргэх нь төсвийн ерөнхийлөн захирагч нарын үүрэг юм. Төрийн байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор; аудитын тайлан, дүгнэлтэд тулгамдаж буй асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор тогтмол мэдээлнэ гэсэн заалтын дагуу мэдээллээ байршуулах ёстой. 2023 онд нийт байгууллагын бараг тал хувь нь (51.8%) нь санхүүгийн аудитын дүгнэлтийг байршуулаагүй байсан. Харин энэ онд 49% болж төдийлөн өөрчлөлт ороогүй байна.

Жил бүр аудитын дүгнэлтийг олон нийтэд ил болгох нь төрийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих боломжийг нэмэгдүүлж, авлига, алдаа зөрчлөөс урьдчилан сэргийлдэг. Санхүүгийн тайлангийн аудит нь тухайн байгууллагын төсвийн зарцуулалтын үр ашиг, хуулийн хэрэгжилт, хариуцлагыг үнэлдэг чухал хэрэгсэл бөгөөд энэ мэдээллийг жил бүр нийтэлснээр ил тод байдал хангагддаг. Эдийн засаг хөгжлийн яам санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтээ жишиг байдлаар оруулсныг онцолж байна.

Шилэн дансны хөтлөлтийн хувьд хэд хэдэн сайжруулах зүйлс анзаарагдсан. Үүнд:

- Байршуулах ёстой мэдээллүүд хугацааны хувьд хоцролттой ордог зөрчлүүд их гардаг ба хамгийн их хоцролттой орж байгаа мэдээлэл нь байгууллагын батлагдсан төсвийг оруулах хэсэг байна. Үүнийг жил бүрийн 1-р сарын 10-ны дотор оруулах шаардлагатай байдаг. Үндэсний Аудитын Газрын 2023 оны тайланд шилэн дансны мэдээлэл байршуулах хугацаа хоцролттой холбоотой зөвлөмжүүдийг тусгасан байдаг байна. Хугацаа хоцроох асуудал нь иргэдийн хяналт тавих боломжийг хязгаарлах эрсдэлтэй учир мэдээлэл байршуулах үйл явц, хуваарьт хатуу хяналт тавих шаардлагатай.
- Төсөв, санхүүгийн тайлан, хөрөнгө оруулалт, тендерийн мэдээлэл дутуу, тодорхой бус байршсан тохиолдлууд их гарсан. Мэдээллийн бүрэн, тодорхой байдлыг хангах үүднээс стандартчилсан загвар ашиглах, тайлан мэдээллийг дахин хянах механизмыг нэвтрүүлэх нь чухал байна.
- Зарим байгууллагын шилэн дансны мэдээлэл харах боломжгүй буюу техникийн алдаа, доголдол их гардаг.
- Шилэн дансны мэдээлэл нарийн, мэргэжлийн хэллэгээр илэрхийлэгдсэн байдаг тул иргэдэд ойлгоход хүндрэлтэй байх магадлалтай. Энгийн, товч тайлбар бүхий интерактив хуудас, график, дүн шинжилгээний нэмэлт боломжуудыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хуульд заасан үзүүлэлтүүдээр хэмжихэд ихэнх байгууллага худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн урилга, баримт бичиг зэрэг мэдээллүүдээ ил тод нээлттэй байршуулсан байна. 2023 онд 40% нь тендер шалгаруулалтын үр дүн болон шалтгаан зэргийг байршуулуулсан байсан бол 2024 онд 51% болж даруй 10%-аар өссөн байна. Шалгаруулалтын үр дүнгийн шалтгааныг тодорхой, ойлгомжтой танилцуулах нь иргэд болон бусад оролцогчдын итгэлийг нэмэгдүүлдэг. Тендерийн шалгаруулалтад оролцогчдын хооронд шударга өрсөлдөөн үүсгэхэд энэ мэдээлэл чухал үүрэгтэй. Тендерт оролцогчид шалтгаан нь ямар байсныг мэдэж, цаашид өрсөлдөх боломж, шалгуур үзүүлэлтүүдийг ойлгох боломжтой. Иймд цаашид төрийн захиргааны байгууллагууд Тендерт шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг өөрсдийн веб сайтад оруулах шаардлагатай байна. Түүнчлэн, 5 сая ба түүнээс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл болон худалдан авах ажиллагааны аудит, бусад шалгалтын тайлан, дүгнэлтийг ихэнх байгууллага байршуулаагүй хэвээр байна. 2023 оноос хойш энэ үзүүлэлт дээр ямар нэг өөрчлөлт гараагүй байна.

Харилцаа холбоо ба эргэх холбоо

Иргэдтэй харилцаа, эргэх холбоо нь тэдний санал хүсэлт, шүүмжлэл, санаачилгыг сонсох боломжийг бий болгодог. Энэ нь төрийн байгууллагуудад нийгмийн хэрэгцээг илүү сайн ойлгох, үйлчилгээний чанарыг сайжруулах боломж олгодог.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.2.1-т

байгууллагууд мэдээллээ олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байдлаар хүргэх үүрэгтэйг зааж

ЗУРАГ 10

Харилцаа холбоо, эргэх холбооны жишээ

өгдөг. Тухайлбал, төрийн байгууллагуудын цахим хуудас дээр иргэдийн санал хүсэлт хүлээн авах хэсэгтэй байх нь ил тод байдал, хариуцлага болон иргэдийн оролцоо гэсэн үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэхэд тусалдаг. Үнэлгээний харилцаа ба эргэх холбоо хэсэг нь жил бүр дунджаар 1%-ийн өсөлттэй байдаг ба 2024 онд өмнөх оноос 0.7%-аар өссөн байна. Нийгмийн сүлжээ рүү холбогдох холбоос, үйлчилгээний линк рүү шууд холбогдох боломж, ямар нэгэн шууд харилцах боломжит хэрэгсэл бий эсэх, үйлчилгээний линк рүү шууд холбогдох боломж зэрэг нь бүх байгууллагад жигд сайн байна.

Харин тогтмол асуудаг асуултуудын хариулт байгаа эсэх, санал асуулга явуулдаг эсэх, өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээ байгаа эсэх зэрэг нь хамгийн бага үзүүлэлттэй хэвээр байна.

Санал хүсэлтийг цахимаар хүлээн авах нь иргэдтэй илүү хурдан, аюулгүй харилцах боломжийг олгодог. Иймд төрийн захиргааны байгууллагууд санал асуулга явуулдаг хэсэгтэй байх, тэрхүү санал хүсэлтийнхээ хариуг веб сайтад нээлттэй байршуулдаг байх шаардлагатай гэж үзэж байна.

2.3. Байгууллагуудын үр дүн

Энэ хэсэгт индексийн үр дүнг байгууллагын түвшинд ангилан, дараах 6 төрлийн байгууллагыг жил бүр хамруулж үр дүнг гаргаж ирсэн.

Цахим ил тод байдлын индекс 2024 онд өнгөрсөн оноос 3.8%-аар өссөн үзүүлэлтийг байгууллагын төрлөөр нь ангилан харахад эдгээр байгууллагын мэдээллийн цахим ил тод байдал бүгд өсжээ.

Ялангуяа эдгээр байгууллагуудаас Тохируулагч агентлаг, Дүүргүүдийн ЗДТГ хамгийн их өсөлтэй байна. Сүүлийн гурван жилийн дунджаас харахад Яам болон Хэрэгжүүлэгч агентлаг жил бүрийн өсөлтөөр тэргүүлдэг бол анх удаа дүүргүүдийн ЗДТГ хамгийн их өсөлтийг үзүүлсэн жил боллоо. Бүрэлдэхүүн тус бүрээр нь харвал Яамд гурван бүрэлдэхүүн хэсгийн аль алинд нь хамгийн өндөр үнэлгээтэй байна.

Яамд сүүлийн таван жилийн хугацаанд 2-3%-ийн өсөлттэй байдаг бол энэ жилийн хувьд

хамгийн бага буюу 1.7%-ийн өсөлттэй байна. Тохируулагч агентлаг болон Дүүргүүдийн ЗДТГ газар жилд дунджаар 1.5-2%-ийн өсөлттэй байдаг бол энэ жилийн хувьд 4.5-5%-ийн өсөлт үзүүлсэн нь сүүлийн 5 жил дэх хамгийн өндөр өсөлт үзүүлсэн жил байв.

Эндээс дүгнэвэл яамд болон хэрэгжүүлэгч агентлагууд өнгөрсөн жилүүдэд цахим ил тод байдлыг дээшлүүлэх чиглэлд тодорхой ажлууд хийж байсан ч Засгийн газрын өөрчлөлттэй холбоотойгоор буурсан байх талтай. Харин Дүүргүүдийн ЗДТГ болон тохируулагч агентлагууд харьцангуй тогтвортой бүтэцтэй байж, тодорхой ажлууд хийсэн гэж таамаглаж болох юм.

Байгууллага тус бүрийн ангиллаар гаргасан эрэмбэтэй тайлангийн Хавсралт 2-оос танилцана уу.

ХҮСНЭГТ 6

Үр дүн, байгууллагын ангиллаар

#	Байгууллагын төрөл	Эрх зүйн орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал	2023 оны индекс	2024 оны индекс	Өөрчлөлт
1	Монгол Улсын Яамд	80.1%	77.8%	59.3%	70.7%	72.4%	+1.7%
2	Хэрэгжүүлэгч агентлагууд	79.8%	76.5%	50.3%	66.8%	68.8%	+2.0%
3	Тохируулагч агентлагууд	79.1%	66.0%	55.1%	63.1%	68.0%	+4.9%
4	Аймгуудын ЗДТГ	79.1%	76.4%	50.6%	66.1%	68.7%	+2.7%
5	Дүүргүүдийн ЗДТГ	78.4%	70.7%	55.0%	63.8%	68.0%	+4.5%
6	Парламентын харьяа байгууллагууд	79.9%	70.5%	52.0%	65.7%	67.5%	+1.8%
Ерөнхий дундаж		79.5%	74.6%	52.9%	65.2%	69.0%	+3.8%

3. Дүгнэлт, зөвлөмж

2024 оны төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын индекс 69% болж, өмнөх оноос 3.8%-аар өссөн нь тогтвортой өсөлтийг илтгэж байна. Сүүлийн 5 жилийн турш цахим ил тод байдлын индекс жил бүр 2.5%-3%-аар нэмэгдэж, төрийн байгууллагуудын цахим үйлчилгээ, ил тод байдалд ахиц дэвшил гарсан нь засгийн газар болон орон нутгийн захиргааны байгууллагуудын цахим засаглалыг сайжруулахад чиглэсэн хүчин чармайлтууд үр дүнгээ өгч байгааг харуулж байна.

Өсөлтийн энэ хандлага хэвээр үргэлжилбэл 2030 онд цахим ил тод байдлын индекс 85% орчимд хүрч, “сайн” түвшинд үнэлэгдэх боломжтой. Ингэснээр төрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, засаглалын ил тод байдал, хариуцлагыг сайжруулахад чухал нөлөө үзүүлэх юм.

Тиймээс, төрийн байгууллагуудын цахим ил тод байдлыг үргэлжлүүлэн сайжруулах нь ил тод байдал, хариуцлагын түвшнийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой байна.

Бодлогын орчны дэд индекс ‘хангалттай’ (79.5%) түвшинд үнэлэгдсэн. Энэ үр дүнг 2023 оны үр дүнтэй харьцуулахад (79.2%) бага зэрэг буюу 0.3% өссөн үзүүлэлт юм. Бодлогын орчинд хамаарах дэд 5 бүлгээр задлан үзэхэд 4 үзүүлэлт нь ахисан байна. Тодруулбал, мэдээлэл авах эрх болон засаглалын үзүүлэлтүүд олон улсын индексүүдийн түвшинд ахисан үзүүлэлттэй байгаа боловч иргэний нийгмийн үзүүлэлт мэдэгдэхүйц (3.8%) буурчээ. Ялангуяа үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэлийн эрх чөлөөний үзүүлэлтүүд буурсан нь гол шалтгаан болж байна. Харин энэ чиглэлээр үндэсний болон байгууллагын түвшинд хэрэгжиж буй бодлого, журмын зохицуулалт бага хэмжээнд сайжирсан байна. Үүнд 2024 оноос шинээр батлагдсан Засгийн газрын баримт бичгүүдэд тодорхой ажлууд туссан, 2022 оноос хэрэгжиж эхэлсэн Нийтийн мэдээллийн тухай хуультай холбоотойгоор 2023 онд байгууллагууд тус хуульд нийцүүлэн гаргасан дотоод дүрэм журмын шинэчлэл хийгдэх үйл явц үргэлжилж байгаа нь эерэг үр дүн гарахад нөлөөлсөн

байна. МУЗГ-т Цахим хөгжил, харилцаа холбооны яам байгуулагдаж тусдаа бүтэц бий болсноор төрийн байгууллагуудын цахимжилт эрчимжиж, мэдээллийг ил тод, нийтэд түргэн шуурхай түгээх байдал нэмэгдэж байна. Гэвч ихэнх байгууллагууд урт болон дунд хугацааны хөгжлийн баримт бичигтээ мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр заалт оруулж өгсөн боловч дийлэнхдээ уламжлалт байдлаар хурал, уулзалт маягаар мэдээлэл түгээх аргыг ашиглах байдлаар тусгагдсан байна. Энэ бүрэлдэхүүн хэсгийг ерөнхийд нь дүгнэвэл мэдээллийг ил тод болгох дэд бүтэц сайжирч байгаа хэдий ч төрийн байгууллагууд дотооддоо мэдээллийг ил тод болгох үйл явцыг цаашид илүү төлөвшүүлэх хэрэгцээ байсаар байна. Мөн төрөөс мэдээлэл өгөх үйл явц хангалттай түвшинд үнэлэгдэж байгаа боловч иргэд, олон нийт, хэвлэл мэдээллийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийн бодлогын орчныг сайжруулах шаардлагатай байгааг анхаарах хэрэгтэй.

Байгууллагын чадамжийн дэд индекс “хангалттай” (74.6%) түвшинд үнэлэгдсэн бөгөөд энэ нь өмнөх оны үр дүнгээс 1.8%-аар өссөн үзүүлэлт юм. Гэсэн хэдий ч энэ өсөлт нь сүүлийн таван жилийн дундаж өсөлт болох 3.9%-тай харьцуулахад хамгийн бага өсөлттэй жил байлаа. Энэхүү бууралт нь байгууллагын чадамжийн тасралтгүй өсөлтийн хандлагад тодорхой хэмжээнд саад учирсныг илтгэж байна. 2024 онд Shilen.gov.mn платформд мэдээлэл оруулах тогтолцоо бүрэн нэвтэрснээс үүдэн ижил төрлийн судалгаанд хамрагдах сонирхол багассан нь цаашид ч буурах эрсдэлтэй байна. Мөн хариуцсан яамнаас www.gov.mn гэх нэгдсэн платформд төрийн байгууллагын вэбсайтыг нэгтгэж байгаа нь зарим байгууллагын мэдээлэл ил тод болгох үйл явцад оролцоо буурсан байх магадлалтай. Гэвч цахим хуудасны технологийн нийцтэй байдал жил бүр тогтвортой өсөлттэй гарсан. Энэ үзүүлэлт нь вэбсайтын технологийн хувьд хэрэглэхэд тохиромжтой эсэхийг үнэлдэг бөгөөд нийт байгууллагын 80% нь вэбсайтын бүтэц хэсгээс бусад бүх үзүүлэлтээ хангаж байна. Вэбсайтын сайжруулалтын үр дүнд иргэд цахим платформыг ашиглан хүнд сурталгүй, хурдан

шуурхай, аль ч газраас, ямар ч төхөөрөмжөөс шаардлагатай мэдээллийг авах боломжтой болж, байгууллагын веб сайтууд технологийн хувьд хурдацтай сайжирч байгаа нь байгууллагын чадамжийн сайжруулалтад тодорхой хэмжээнд хувь нэмэр оруулж байна.

Байгууллагын чадамж хэсэгт гарсан голлох үр дүнгээс дурдвал:

- Төрийн захиргааны 98 байгууллагын ердөө 27% нь вэбсайтынхаа хандалтын мэдээллийг ил тод харуулж байна, харин үлдсэн байгууллагууд хандалтын мэдээллийг ил тод болгоогүй хэвээр байна. Зарим вэб сайтуудын хандалтын мэдээлэл үнэн зөв биш байх магадлалтай. Жишээлбэл, Увс аймгийн вэбсайт өдөрт 793,290 хандалттай гэж заасан ч, долоо хоногийн хандалт нь мөн адил 793,290 гэж харагдсан нь системийн алдаа байж болзошгүйг харуулж байна.
- Цахим ил тод байдлын гүйцэтгэлийг тогтмол хянаж, үнэлэх явц сайжирч байгаа ч хангалтгүй хэвээр байна. 2024 онд Засгийн газрын шилэн ажиллагаатай холбоотойгоор судалгаанд хамрагдсан байгууллагын 61% нь цахим ил тод байдлын гүйцэтгэлээ тогтмол хянаж, үнэлдэг болсон нь өнгөрсөн жилтэй харьцуулахад 10%-аар өссөн үзүүлэлт юм.
- Цахим ил тод байдлын бодит байдал, үнэлгээний найдвартай байдлыг сайжруулахын тулд төрийн байгууллагууд хандалтын мэдээллийг стандартчилах, мэдээллийн үнэн зөв байдлыг баталгаажуулах, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна.
- Төсөв санхүүгийн дутагдал цахим ил тод байдлын хэрэгжилтэд саад болж байна. 2023 онд төрийн байгууллагуудын 62% нь тодорхой хэмжээний төсөвтэй гэж хариулсан бол 2024 онд энэ үзүүлэлт 65%-д хүрсэн ч, 70% нь төсөв хүрэлцээгүй хэвээр байгааг онцолсон байна.
- Цахим хуудасны технологийн нийцтэй байдал тогтвортой өсөж байгаа ч, цахим ил тод байдлын бодлогын хэрэгжилт удаан байна. Сүүлийн 5 жилийн дотор цахим ил тод байдлыг хангах стратеги бүхий байгууллагын тоо ердөө 2%-аар л өссөн нь энэ чиглэлийн бодлого, төлөвлөлтийг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна. Мэдээлэлтэй холбоотой давхардал, хүнд

суртал, зардлыг бууруулахын тулд цахим ил тод байдлыг хангах стратеги, төлөвлөгөөтэй байх нь зайлшгүй шаардлагатай ч 2024 оны байдлаар ийм стратеги бүхий байгууллагын тоо ердөө 51%-д хүрсэн нь хангалтгүй үзүүлэлт юм.

- Мэдээллийг ил тод болгох үүрэг бүхий ажилтангүй байгууллагуудын тоо 2024 онд тэг болсон нь Shilen.gov.mn платформын нөлөөгөөр бүх байгууллага мэдээллийн хариуцагчтай болсныг илтгэж байна.
- Төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын гүйцэтгэл сайжирч байгаа ч, хүний нөөцийн мэдээлэл шинэчлэгддэггүй, мөн мэдээллийн шинэчлэлтийг баталгаажуулах нотлох баримт байхгүй нь ил тод байдлыг бүрэн хангаж чадахгүй байна.

Мэдээллийн цахим нээлттэй байдлын дэд индекс 'сул' (52.8%) түвшинд үнэлэгдсэн бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуулахад 5.3%-иар өссөн үзүүлэлт юм. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль батлагдсанаар цахим нээлттэй байдлын индекс сүүлийн хоёр жилд буурч байсан бол 2024 онд өсжээ. Тус хууль батлагдахаас өмнө энэ бүрэлдэхүүн хэсэг нь сул түвшинд үнэлэгдэж байсан бол хууль батлагдсаны дараа хангалтгүй түвшинд буурсан. Харин 2024 онд дахин сул түвшинд үнэлэгдэх болсон нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт төрийн байгууллагуудын түвшинд тогтворжиж, цахим нээлттэй байдлын хандлага эргэж сайжирч байгааг харуулж байна.

Цахим нээлттэй байдлын хэсэгт гарсан голлох үр дүнгээс дурдвал:

- Хамгийн их өсөлт үзүүлсэн үзүүлэлтүүд нь хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан зэрэгдгээр мэдээллийг нийт байгууллагын 80%-иас дээш нь вебсайтаа байршуулжээ.
- Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тайлан нь хамгийн бага оноотой үзүүлэлт болсон бөгөөд энэ нь олон нийтийн итгэл, эрх зүйн хариуцлага, харилцааны хүртээмжийг сайжруулах чухал мэдээлэл байсаар байна.
- Шилэн дансны мэдээлэл нийтлэх үйл ажиллагаанд хэд хэдэн доголдол гарч байгаа

бөгөөд байршуулах ёстой мэдээллүүд хугацааны хоцрогдолтой, мэдээлэл дутуу, тодорхойгүй нийтлэгдэж байгаа асуудлууд хэвээр байна.

- Төрийн байгууллагууд аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээг ил тод нийтлэх үүрэгтэй ч мэдээлэл оруулсан байдал 2024 онд өмнөх оноос ердөө 3%-ийн өсөлттэй буюу 48%-д хүрсэн байна.
- Худалдан авах ажиллагааны ил тод байдал сайжирсан ч 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл болон аудитын тайлангуудыг олон байгууллага байршуулаагүй хэвээр байгаа нь асуудал дагуулж байна.
- Тендер шалгаруулалтын үр дүн, шалтгааныг тодорхой нийтлэх нь ил тод байдал, шударга өрсөлдөөнийг хангахад чухал үүрэгтэй ч, 2023 онд 40% нь энэ мэдээллийг нийтлээгүй байсан бол 2024 онд 51% болж өссөн нь эерэг өөрчлөлт болж байна.
- Иргэдийн санал хүсэлтийг цахимаар хүлээн авах, хариуг нь ил тод нийтлэх нь төрийн байгууллагуудын хариуцлага, нээлттэй байдлыг сайжруулах чухал хэрэгсэл бөгөөд цаашид энэ чиглэлээр илүү анхаарч ажиллах шаардлагатай байна.

Үнэлгээний үр дүнд үндэслэн цаашид төрийн байгууллагууд мэдээллийн цахим ил тод байдлаа сайжруулах дараах санал зөвлөмжүүдийг хүргэж байна. Үүнд:

- Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн тайлан мэдээг цаг тухай бүрд нь оруулах
- Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийг нарийвчлан оруулах
- Аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг цаг тухай бүрд нь оруулах
- Шилэн дансанд байршуулах ёстой мэдээллүүд хугацааны хувьд хоцрогдолгүй оруулах
- Оруулж буй мэдээллийн бүрэн, тодорхой байдлыг хангах үүднээс стандартчилсан загвар ашиглах, тайлан мэдээллийг дахин хянах механизмыг нэвтрүүлэх
- Шилэн дансны ажиллагааны тогтмол байдлыг хангах
- Шилэн дансны үг хэллэгийг энгийн, товч тайлбар бүхий интерактив хуудас, график, дүн шинжилгээний нэмэлт боломжуудыг хэрэгжүүлэх
- Тогтмол асуудаг асуултуудын хариулт, санал асуулга явуулах хэсэг, өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээ зэргийг веб сайт дээр тогтмол мэдээлэх

Хавсралт 1. Арга зүй: Хэмжих индикаторууд, харгалзах оноо

Код	Индикаторууд	Дээд оноо
Е. Бодлогын орчин		57
Е1. Мэдээлэл авах эрх (Олон улс)		8
E1.1	Мэдээлэл хүсэх эрх	2
E1.2	Мэдээллийн цар хүрээ	1
E1.3	Мэдээлэл хүсэх журам	1
E1.4	Татгалзал	1
E1.5	Гомдол гаргах	1
E1.6	Санкц ба хамгаалалт	1
E1.7	Таниулах арга хэмжээ	1
Е2. Засаглал (Олон улс)		12
E2.1	Хуулийн хэрэгжилт	2
E2.2	Дуу хоолой ба хариуцлага	1
E2.3	Зохицуулалтын чанар	1
E2.4	Засгийн газрын үр нөлөөтэй байдал	1
E2.5	Төрийн төлөв байдал	4
E2.6	Төрийн үйл ажиллагаа	3
Е3. Иргэний нийгэм (Олон улс)		15
E3.1	Иргэний оролцоо	2
E3.2	Хэвлэлийн эрх өлөө	1
E3.3	Иргэний нийгмийн төлөв байдал	1
E3.4	Цахим оролцоо	1
E3.5	Иргэний эрх чөлөөний хяналт (эрх зүйн)	1
E3.6	Засаглалд иргэдийг оролцуулах	4
E3.7	Эрх чөлөө	5
Е4. Улсын түвшний бодлого, зохицуулалт		14
E4.1	Хууль, журам	5
E4.2	Бодлого төлөвлөлт	5
E4.3	Хэрэгжүүлэх субъект	3
E4.4	Хяналт тавих механизм	1
Е5. Байгууллагын түвшний зохицуулалт		8
E5.1	Зохицуулалт	8
О. Байгууллагын чадамж		29
О1. Байгууллагын ил тод байдлыг хангах үйл явц ба нөөц		12
O1.1	Нөөцийн боломжит байдал	3
O1.2	Манлайлал	5
O1.3	Тасралтгүй сайжруулах чадавх	4
О2. Цахим хуудасны технологийн нийцтэй байдал		11
O2.1	Цахим хуудасны нийцтэй байдал	11
О3. МХТ-ийн чадавх		6
O3.1	МХТ-ийн чадавх	6
Д. Цахим нээлттэй мэдээлэл		48
Д1. Нээлттэй мэдээлэл		39
O1.1	Нөөцийн боломжит байдал	3
D1.1	Үйл ажиллагааны ил тод байдал	13
D1.2	Хүний нөөцийн ил тод байдал	9
D1.3	Төсөв, санхүүгийн ил тод байдал	10
D1.4	Худалдан авах ажиллагааны ил тод байдал	7
Д2. Харилцаа холбоо ба эгэх холбоо		9
D2.1	Харилцаа ба эгэх холбоо	9
Нийт		150

Хавсралт 2. Байгууллагын төрөл тус бүрийн эрэмбэ

Сайн | >80

Хангалттай | 65-79

Сул | 50-64

Хангалтгүй | 35-49

Муу | <35

Яамдын цахим ил тод байдал

#	Байгууллагууд	Цахим ил тод байдлын индекс	Бодлогын орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал
1	Зам, тээврийн хөгжлийн яам	80.0%	78.1%	92%	70%
2	Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам	78.7%	78.1%	93%	65%
3	Байгаль орчин аялал жуулчлалын яам	77.0%	79.1%	91%	61%
4	Сангийн яам	76.7%	78.1%	84%	68%
5	Цахим хөгжил харилцаа холбооны яам	74.7%	78.1%	81%	65%
6	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	72.9%	78.6%	91%	49%
7	Боловсрол шинжлэх ухааны яам	72.7%	86.1%	68%	64%
8	Гадаад харилцааны яам	72.0%	84.1%	77%	55%
9	Барилга хот байгуулалтын яам	71.0%	81.1%	65%	67%
10	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	70.7%	78.1%	64%	70%
11	Батлан хамгаалах яам	70.4%	86.1%	68%	57%
12	Эрүүл мэндийн яам	70.0%	83.1%	77%	50%
13	Соёлын яам	69.4%	78.1%	72%	58%
14	Эдийн засаг, хөгжлийн яам	68.0%	78.1%	74%	52%
15	Хууль, зүй дотоод хэргийн яам	67.4%	78.1%	74%	50%
16	Эрчим хүчний яам	67.0%	78.1%	74%	49%
Яамдын индекс		72.4%	80.1%	77.8%	59.4%
Улсын цахим ил тод байдлын индекс		68.9%	79.5%	74.6%	52.8%

Тохируулагч агентлагуудын цахим ил тод байдал

#	Байгууллагууд	Цахим ил тод байдлын индекс	Бодлогын орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал
1	Биеийн тамир, спортын улсын хороо	74.2%	83.6%	89%	50%
2	Цагдаагийн ерөнхий газар	72.9%	83.6%	78%	57%
3	Монополын эсрэг газар	69.4%	78.1%	80%	50%
4	Төрийн тусгай хамгаалалтын газар	69.4%	78.1%	68%	62%
5	Хил хамгаалах ерөнхий газар	66.4%	78.1%	58%	63%
6	Онцгой байдлын ерөнхий газар	65.9%	81.6%	63%	53%
7	Стандарт, хэмжил зүйн газар	65.7%	78.1%	68%	51%
8	Соёл, урлагийн газар	65.0%	78.1%	65%	52%
9	Зэвсэгт хүчний жанжин штаб	65.0%	78.1%	69%	48%
10	Тагнуулын ерөнхий газар	64.4%	78.1%	55%	60%
11	Иргэний нисэхийн ерөнхий газар	63.5%	83.6%	64%	43%
Тохируулагч агентлагийн индекс		67.4%	79.9%	68.8%	53.5%
Улсын цахим ил тод байдлын индекс		68.9%	79.5%	74.6%	52.8%

Сайн | >80

Хангалттай | 65-79

Сул | 50-64

Хангалтгүй | 35-49

Муу | <35

Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим ил тод байдал

#	Байгууллагууд	Цахим ил тод байдлын индекс	Бодлогын орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал
1	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	82.9%	84.6%	96%	68%
2	Татварын ерөнхий газар	74.4%	78.1%	86%	59%
3	Ойн газар	74.4%	84.1%	82%	57%
4	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	74.2%	83.6%	89%	50%
5	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	73.4%	78.1%	84%	58%
6	Цаг уур, орчны шинжилгээний газар	73.2%	78.6%	83%	58%
7	Биеийн тамир, спортын газар	73.0%	78.1%	90%	51%
8	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	73.0%	78.1%	89%	52%
9	Усны газар	72.7%	84.1%	77%	57%
10	Боловсролын ерөнхий газар	72.0%	78.1%	92%	46%
11	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	71.4%	79.1%	85%	50%
12	Шүүх шинжилгээний ерөнхий газар	70.0%	78.1%	79%	53%
13	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	69.4%	78.1%	80%	50%
14	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	69.0%	78.1%	91%	38%
15	Үндэсний геологийн алба	69.0%	80.1%	79%	48%
16	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	68.2%	82.6%	78%	44%
17	Гадаадын иргэн, харьяатын газар	67.4%	78.1%	74%	50%
18	Нийгмийн даатгалын ерөнхий газар	67.4%	78.1%	70%	54%
19	Ашигт малтмал, газрын тосны газар	66.7%	78.1%	78%	44%
20	Төрийн худалдан авах ажиллагааны газар	65.9%	83.6%	74%	40%
21	Улсын бүртгэлийн ерөнхий газар	65.7%	78.1%	72%	47%
22	Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	65.4%	78.1%	66%	52%
23	Мал эмнэлгийн ерөнхий газар	64.7%	78.1%	73%	43%
24	Жижиг, дунд үйлдвэрийн газар	64.7%	78.1%	70%	46%
25	Оюуны өмчийн газар	64.7%	78.1%	71%	45%
26	Архивын ерөнхий газар	64.0%	84.1%	64%	44%
27	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	64.0%	78.1%	54%	60%
28	Хөрөнгө оруулалт худалдааны газар	63.5%	83.6%	64%	43%
29	Гаалийн ерөнхий газар	63.4%	78.1%	60%	52%
30	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	63.0%	78.1%	65%	46%
Хэрэгжүүлэгч агентлагийн индекс		68.7%	79.5%	76.2%	50.3%
Улсын цахим ил тод байдлын индекс		68.9%	79.5%	74.6%	52.8%

Сайн | >80

Хангалттай | 65-79

Сул | 50-64

Хангалтгүй | 35-49

Муу | <35

Аймгийн ЗДТГ-уудын цахим ил тод байдал

#	Байгууллагууд	Цахим ил тод байдлын индекс	Бодлогын орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал
1	Өвөрхангай аймаг	78.9%	78.6%	94%	64%
2	Орхон аймаг	75.0%	78.1%	93%	54%
3	Увс аймаг	74.4%	78.1%	93%	52%
4	Сэлэнгэ аймаг	73.4%	78.1%	89%	53%
5	Дундговь аймаг	73.0%	78.1%	89%	52%
6	Завхан аймаг	72.4%	78.1%	94%	45%
7	Хэнтий аймаг	72.0%	80.1%	85%	51%
8	Архангай аймаг	71.0%	80.1%	83%	50%
9	Булган аймаг	70.0%	78.1%	75%	57%
10	Баянхонгор аймаг	67.0%	80.1%	77%	44%
11	Говь-Алтай аймаг	66.4%	78.1%	77%	44%
12	Дархан-Уул аймаг	66.2%	79.6%	77%	42%
13	Дорноговь аймаг	66.0%	80.1%	55%	63%
14	Ховд аймаг	65.9%	78.6%	78%	41%
15	Баян-Өлгий аймаг	65.5%	82.6%	74%	40%
16	Өмнөговь аймаг	65.2%	78.6%	62%	55%
17	Дорнод аймаг	65.0%	80.1%	77%	38%
18	Говьсүмбэр аймаг	65.0%	80.1%	63%	52%
19	Сүхбаатар аймаг	64.0%	78.1%	51%	63%
20	Төв аймаг	63.2%	78.6%	59%	52%
21	Хөвсгөл аймаг	62.9%	78.6%	60%	50%
22	Улаанбаатар хотын захирагчийн алба	66.2%	78%	85%	45%
Аймаг, нийслэлийн дундаж		68.7%	79.1%	76.4%	50.7%
Улсын цахим ил тод байдлын индекс		68.9%	79.5%	74.6%	52.8%

Дүүргийн ЗДТГ-уудын цахим ил тод байдал

#	Байгууллагууд	Цахим ил тод байдлын индекс	Бодлогын орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал
1	Хан-Уул дүүрэг	76.4%	78.1%	85%	66%
2	Налайх дүүрэг	74.0%	78.1%	87%	57%
3	Баянзүрх дүүрэг	72.0%	78.1%	86%	52%
4	Улаанбаатар хотын захирагчийн алба	71.7%	78.1%	85%	52%
5	Багахангай дүүрэг	67.0%	78.1%	69%	54%
6	Сүхбаатар дүүрэг	64.9%	79.6%	55%	60%
7	Чингэлтэй дүүрэг	64.2%	78.6%	64%	50%
8	Багануур дүүрэг	64.0%	78.1%	62%	52%
9	Сонгинохайрхан дүүрэг	63.2%	78.6%	57%	54%
10	Баянгол дүүрэг	62.7%	78.1%	57%	54%
Дүүргүүдийн дундаж		68%	78.4%	70.7%	55%
Улсын цахим ил тод байдлын индекс		68.9%	79.5%	74.6%	52.8%

Сайн | >80

Хангалттай | 65-79

Сул | 50-64

Хангалтгүй | 35-49

Муу | <35

Парламентын харьяа байгууллагуудын цахим ил тод байдал

#	Байгууллагууд	Цахим ил тод байдлын индекс	Бодлогын орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал
1	Монгол банк	74.9%	81.6%	77%	66%
2	Санхүүгийн зохицуулах хороо	70.5%	79.6%	69%	63%
3	Үндэсний статистикийн хороо	69.2%	85.6%	69%	53%
4	Сонгуулийн ерөнхий хороо	68.4%	78.1%	76%	51%
5	Хүний эрхийн үндэсний комисс	67.0%	78.1%	77%	46%
6	Авилагтай тэмцэх газар	66.4%	80.1%	69%	50%
7	Төрийн албаны зөвлөл	66.4%	78.1%	62%	59%
8	Жендерийн үндэсний хороо	64.9%	79.6%	69%	46%
9	Үндэсний аудитын газар	64.0%	78.1%	72%	42%
10	Монгол улсын их хурал	63.0%	80.1%	65%	44%
Парламентын харьяа байгууллагын индекс		67.5%	79.9%	70.5%	52%
Улсын цахим ил тод байдлын индекс		68.9%	79.5%	74.6%	52.8%

Хавсралт 3. Нийт үнэлсэн төрийн байгууллагуудын эрэмбэ

Сайн | >80 Хангалттай | 65-79 Сул | 50-64 Хангалтгүй | 35-49 Муу | <35

Эрэмбэ	Байгууллагууд	2022 оны индекс	2023 оны индекс	Өөрчлөлт
1	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	80.5%	82.9%	2.4%
2	Зам, тээврийн хөгжлийн яам	81%	80.0%	-1.0%
3	Өвөрхангай аймаг	77.5%	78.9%	1.4%
4	Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам	77.0%	78.7%	1.7%
5	Байгаль орчин аялал жуулчлалын яам	76.3%	77.0%	0.7%
6	Сангийн яам	75.7%	76.7%	1.0%
7	Хан-Уул дүүрэг	69.3%	76.4%	7.1%
8	Орхон аймаг	74.3%	75.0%	0.7%
9	Монгол банк	74.5%	74.9%	0.4%
10	Цахим хөгжил харилцаа холбооны яам	73.0%	74.7%	1.7%
11	Татварын ерөнхий газар	74.3%	74.4%	0.1%
11	Ойн газар	69.7%	74.4%	4.7%
11	Увс аймаг	70.7%	74.4%	3.7%
12	Биеийн тамир, спортын улсын хороо	70.0%	74.2%	4.2%
13	Налайх дүүрэг	73.3%	74.0%	0.7%
14	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	70.0%	73.4%	3.4%
14	Сэлэнгэ аймаг	69.7%	73.4%	3.7%
15	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	73.2%	73.2%	0.0%
16	Цаг уур, орчны шинжилгээний газар	70.0%	73.0%	3.0%
16	Биеийн тамир, спортын газар	70.0%	73.0%	3.0%
16	Дундговь аймаг	69.7%	73.0%	3.3%
17	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	73.1%	72.9%	-0.2%
17	Цагдаагийн ерөнхий газар	72.2%	72.9%	0.7%
18	Боловсрол шинжлэх ухааны яам	68.7%	72.7%	4.0%
18	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	72.7%	72.7%	0.0%
19	Завхан аймаг	71.0%	72.4%	1.4%
20	Гадаад харилцааны яам	72.7%	72.0%	-0.7%
20	Усны газар	72.3%	72.0%	-0.3%
20	Хэнтий аймаг	68.7%	72.0%	3.3%
20	Баянзүрх дүүрэг	71.3%	72.0%	0.7%
21	Улаанбаатар хотын захирагчийн алба	69.3%	71.7%	2.4%
22	Боловсролын ерөнхий газар	67.7%	71.4%	3.7%
23	Барилга хот байгуулалтын яам	73.1%	71.0%	-2.1%
23	Архангай аймаг	69.7%	71.0%	1.3%
24	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	63.7%	70.7%	7.0%
25	Санхүүгийн зохицуулах хороо	70.5%	70.5%	0.0%
26	Батлан хамгаалах яам	65.7%	70.4%	4.7%
27	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	62.7%	70.0%	7.3%
27	Булган аймаг	67.3%	70.0%	2.7%
27	Эрүүл мэндийн яам	69.3%	70.0%	0.7%
28	Монополын эсрэг газар	68.3%	69.4%	1.1%
28	Шүүх шинжилгээний ерөнхий газар	68.7%	69.4%	0.7%
28	Соёлын яам	67.0%	69.4%	2.4%
28	Төрийн тусгай хамгаалалтын газар	72.5%	69.4%	-3.1%

Эрэмбэ	Байгууллагууд	2022 оны индекс	2023 оны индекс	Өөрчлөлт
29	Үндэсний статистикийн хороо	68.5%	69.2%	0.7%
30	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	68.3%	69.0%	0.7%
30	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	66.7%	69.0%	2.3%
31	Сонгуулийн ерөнхий хороо	65.3%	68.4%	3.1%
32	Үндэсний геологийн алба	67.2%	68.2%	1.0%
33	Эдийн засаг, хөгжлийн яам	66.3%	68.0%	1.7%
34	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	64.3%	67.4%	3.1%
34	Гадаадын иргэн, харьяатын газар	62.3%	67.4%	5.1%
34	Хууль, зүй дотоод хэргийн яам	63.7%	67.4%	3.7%
35	Баянхонгор аймаг	67%	67.0%	0.0%
35	Хүний эрхийн үндэсний комисс	63.7%	67.0%	3.3%
35	Эрчим хүчний яам	65.3%	67.0%	1.7%
35	Багахангай дүүрэг	62.0%	67.0%	5.0%
36	Нийгмийн даатгалын ерөнхий газар	64.3%	66.7%	2.4%
37	Говь-Алтай аймаг	63.0%	66.4%	3.4%
37	Авилагтай тэмцэх газар	64.0%	66.4%	2.4%
37	Төрийн албаны зөвлөл	60.0%	66.4%	6.4%
37	Хил хамгаалах ерөнхий газар	58.7%	66.4%	7.7%
38	Дархан-Уул аймаг	66.2%	66.2%	0.0%
39	Дорноговь аймаг	70.0%	66.0%	-4.0%
40	Ашигт малтмал, газрын тосны газар	65.8%	65.9%	0.1%
40	Төрийн худалдан авах ажиллагааны газар	65.2%	65.9%	0.7%
40	Ховд аймаг	64.2%	65.9%	1.7%
40	Онцгой байдлын ерөнхий газар	63.0%	65.9%	2.9%
41	Улсын бүртгэлийн ерөнхий газар	63.0%	65.7%	2.7%
41	Стандарт, хэмжил зүйн газар	64.0%	65.7%	1.7%
42	Баян-Өлгий аймаг	65.2%	65.5%	0.3%
42	Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	62.0%	65.4%	3.4%
43	Өмнөговь аймаг	63.2%	65.2%	2.0%
44	Дорнод аймаг	63.0%	65.0%	2.0%
44	Говьсүмбэр аймаг	61.7%	65.0%	3.3%
44	Соёл, урлагийн газар	61.3%	65.0%	3.7%
44	Зэвсэгт хүчний жанжин штаб	62.7%	65.0%	2.3%
45	Жендерийн үндэсний хороо	64.2%	64.9%	0.7%
45	Сүхбаатар дүүрэг	58.2%	64.9%	6.7%
46	Мал эмнэлгийн ерөнхий газар	64.3%	64.7%	0.4%
46	Жижиг, дунд үйлдвэрийн газар	64.0%	64.7%	0.7%
46	Оюуны өмчийн газар	62.3%	64.7%	2.4%
47	Тагнуулын ерөнхий газар	59.7%	64.4%	4.7%
48	Чингэлтэй дүүрэг	60.2%	64.2%	4.0%
49	Үндэсний аудитын газар	63.3%	64.0%	0.7%
49	Архивын ерөнхий газар	62.3%	64.0%	1.7%
49	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	58.7%	64.0%	5.3%
49	Багануур дүүрэг	67.7%	64.0%	-3.7%
49	Сүхбаатар аймаг	55.7%	64.0%	8.3%
50	Иргэний нисэхийн ерөнхий газар	63.2%	63.5%	0.3%
51	Хөрөнгө оруулалт худалдааны газар*		63.4%	NA
52	Сонгинохайрхан дүүрэг	59.8%	63.2%	3.4%
52	Төв аймаг	57.5%	63.2%	5.7%

* Шинээр байгуулагдсан болон өмнөх жилд хамрагдаагүй байгууллагууд

Эрэмбэ	Байгууллагууд	2022 оны индекс	2023 оны индекс	Өөрчлөлт
53	Монгол улсын их хурал	63.0%	63.0%	0.0%
53	Гаалийн ерөнхий газар	59.0%	63.0%	4.0%
54	Хөвсгөл аймаг	58.8%	62.9%	4.1%
55	Баянгол дүүрэг	59.0%	62.7%	3.7%
56	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	57.7%	61.7%	4.0%

* Шинээр байгуулагдсан болон өмнөх жилд хамрагдаагүй байгууллагууд